

**Монгол улс: Банкны хяналт шалгалт болон Мөнгөний
бодлогын ил тод байдлын стандарт, хэм хэмжээний мөрдөлтөнд хийсэн
үнэлгээний тайланг багтаасан Санхүүгийн Салбарын Тогтвортой Байдлын
Үнэлгээ**

Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн Банкны хамтарсан ажлын хэсэг гишүүн орнуудтайгаа явуулдаг байнгын хэлэлцүүлгийн тулгуур баримт бичиг болгон ашиглах зорилгоор Монгол улсын Санхүүгийн Салбарын Тогтвортой Байдлын Үнэлгээг боловсруулж гаргалаа. Энэхүү баримт бичгийг боловсруулж дуусгасан өдөр буюу 2008 оны 5-р сарын 13 –ны өдрийн байдлаар бэлэн байсан мэдээллүүдэд үндэслэж бэлтгэсэн болно. Энэхүү баримт бичгүүд нь ажлын хэсгийн гишүүдийн байр суурийг тусгасан ба тэдгээр нь Монгол улсын Засгийн газар болон ОУВС-гийн Гүйцэтгэх Захирлуудын Зөвлөлийн байр суурь болохгүйг үүгээр мэдэгдэж байна.

Ажлын хэсгийн тайлангууд болон бусад холбогдох баримт материалуудыг нийтлэхдээ ОУВС-гийн хэвлэн нийтлэх бодлогын хүрээнд зах зээлийн хувьд мэдрэмтгий мэдээ мэдээллийг хасч нийтэлж болно.

Энэхүү тайланг доорхи хаягаар хандаж авч болно.

International Monetary Fund, Publication Services
700 19th street, N.W. Washington, D.C. 20431
Утас: (202) 623-7430, Факс: (202) 623-7201
Цахим шуудан: publications@imf.org
Вэб хаяг: <http://www.imf.org>

Үнэ: нэг хувь нь 18.00 ам.доллар

**Олон Улсын Валютын Сан
Вашингтон, К. Т.**

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН

МОНГОЛ УЛС

Санхүүгийн Салбарын Тогтвортой Байдлын Үнэлгээ

Мөнгө, Хөрөнгийн Зах болон Ази Номхон Далайн Бүсийн Газруудаас бэлдэв.

Жайми Каруана болон Даниэл Ситрин нар батлав.

2008 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Санхүүгийн Салбарын Тогтвортой Байдлын Үнэлгээний (ССТБҮ) энэхүү баримт бичиг нь 2007 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 4-ний өдрүүд, 2007 оны 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажилласан ОУВС, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлсэн Санхүүгийн Салбарын Үнэлгээний Хөтөлбөр (ССҮХ)-ийн ажлын хэсгийн үр дүн болно.

ССҮХ-ийн ажлын хэсэг Марк О Брайн (ажлын хэсгийн ахлагч, ОУВС), Самир Гоял (ажлын хэсгийн орлогч ахлагч, Дэлхийн банк), Сэюнг Хо Ли, Елена Лукьянова, Василий Прокопенко, Шайна Переира (бүгд ОУВС), Виллиам Бритт Жвиннер, Шаофенг Хуа, Флоренсия Моизешович, Бикки Рандава (бүгд Дэлхийн банк), Ричард Бриттон (Их Британи Улсын Санхүүгийн Үйлчилгээний Зохицуулах газарт ажиллаж байсан), Стефан Спамер (Дойче Бундесбанк) болон Уолтер Зуник (АНУ-ын Холбооны Нөөцийн Санд ажиллаж байсан) нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Ажлын хэсэг эрх бүхий байгууллагуудтай үр дүнтэй хамтарч, зохих туслалцааг бүрэн авч байлаа. Үнэлгээний үр дүнд дараах үндсэн дүгнэлтүүдийг гаргасан болно. Үүнд:

Монгол улсын санхүүгийн системийн хөгжил, үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь эдийн засгийн ерөнхий байдалтайгаа уялдан сайн байгаа хэдий ч тодорхой асуудлуудтай тулгарч байна. Эдийн засгийн хэт халалтын шинж тэмдгүүд илэрч, цөөн тооны бүтээгдэхүүний экспортоос ихээхэн хамааралтай байдал болон зээлийн өсөлт хурдацтай байгаа нь эрсдлийн хүчин зүйлүүд болж байна. Үүнээс гадна системийн хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо болон санхүүгийн аюулгүйн сүлжээний хөгжлийн түвшин доогуур байгаа нь системийн цочрол шингээх чадварыг хязгаарлаж, улмаар ирээдүйд үүсч болзошгүй аливаа хүндрэл, асуудлын хариуцлага эрх баригчид дээр ирэхээр байна.

Хэдийгээр банкны хяналт шалгалтын тогтолцоо харьцангуй сайн хөгжсөн боловч түүний хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ байна. Банкны бус санхүүгийн байгууллага болон хөрөнгийн захын хяналт шалгалтын үйл ажиллагаа хөгжлийн эхний шатандаа байгаа нь эрсдэлийг үүсгэж болзошгүй цоорхойтой хэдий ч банкны бус санхүүгийн салбарын хэмжээ өнөөг хүртэл харьцангуй бага байгаа нь системийн гэхээсээ илүү нэр хүндийн эрсдлийн хүчин зүйл болно.

Санхүүгийн системийн хөгжлийг дэмжих хэд хэдэн чухал шинэчлэлийн арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлсэн, эсхүл төлөвлөгдөөд явж байна. Эдгээрийг тун хянуур тодорхойлж, хэрэгжүүлэх дарааллыг зөв тогтоох нь тэдгээрийн амжилттай хэрэгжилтийг хангах, үүсч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийхэд чухал ач холбогдолтой. Мөн хууль эрх зүйн орчин болон бусад дэд бүтцийг сайжруулахыг дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага байна.

Тус тайлангийн гол зохиогчид нь Марк О'Брайн болон Василий Прокопенко нар болно.

ССҮХ нь аль нэг байгууллагыг онцлохгүйгээр санхүүгийн системийн тогтвортой байдлыг бүхэлд нь үнэлэх зорилготой. Энэхүү хөтөлбөр нь улс орны санхүүгийн салбарын бүтцэд оршиж буй сул талыг илрүүлж арилгахад туслах, ингэснээр үүсч болзошгүй макро эдийн засгийн аливаа шок, хил дамнасан нөлөөлөх хүчин зүйлд тэсвэртэй болгох зорилгоор боловсруулагдсан. ССҮХ-ийн хүрээнд активын чанар, үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэл, гэмт хэрэг зэрэг тухайн нэр заасан байгууллагад хамаарах эрсдлийг хамааруулдаггүй.

	Агуулга	Хуудас
Нэр томъёо		6
Хураангуй		7
I. Санхүүгийн салбарын бүтэц, үүсч болзошгүй эрсдэл		11
А. Бүтэц.....		11
Б. Макроэдийн засгийн орчинд оршиж буй эрсдэл.....		11
В. Санхүүгийн системийн үндсэн оролцогчид		15
II. Банкны салбарын сайн болон сул талууд		15
А. Үр дүнгийн үзүүлэлтүүд		15
Б. Цочролын сорил.....		19
В. Системийн хөрвөх чадвар		20
Г. Санхүүгийн системийн дэд бүтэц.....		21
III. Санхүүгийн тогтвортой байдлын тогтолцоо		23
А. Хяналт шалгалт болон зохицуулалтын тогтолцоо.....		23
Б. Санхүүгийн системийн аюулгүйн сүлжээ.....		25
В. Мөнгөний бодлогын ил тод байдал болон Төв банкны зохистой удирдлага		25
Г. Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг/Терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУҮАЭ/ТСТ) ажлын хүрээнд		26
Д. Нягтлан бодох бүртгэл болон аудитын стандартууд.....		27
Е. Компанийн зохистой удирдлага.....		27
IV. Санхүүгийн системийн хөгжлийн нэн тэргүүний тулгамдсан асуудлууд		28
А. Орон сууцны санхүүжилт.....		28
Б. Хөрөнгийн зах зээлийн хөгжил.....		29
В. Хөгжлийн банк		30
Г. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж		30
Хүснэгт		
1. Санхүүгийн системийн бүтэц		14
2. Банкны салбарын эрүүл байдлын үндсэн үзүүлэлтүүд.....		17
3. Банкны үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд		33
4. Мэдрэмтший байдлын шинжилгээний товч үр дүн.....		36
5. Базелийн үндсэн зарчмуудын хэрэгжилтийн үнэлгээний хураангуй.....		44
6. Базелийн үндсэн зарчмуудын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр зөвлөмж болгосон ажлын төлөвлөгөө.....		48
7. Мөнгөний бодлогын ил тод байдлын хэм хэмжээнд хийсэн ажиглалтын хураангуй 53		
8. Мөнгөний бодлогын ил тод байдлыг сайжруулах талаар авч явуулах үйл		

ажиллагааны төлөвлөгөөний зөвлөмж 56

Хайрцаг

1. Монгол улс: ССҮХ-аас өгсөн үндсэн зөвлөмж10

Хавсралт

1. Цочролын сорил явуулах аргачлал болон суурь таамаглалууд.....32

2. Хадгаламж зээлийн хоршоодын хяналт шалгалт..... 38

Нэмэлт хавсралт

I. Санхүүгийн салбарын зарим стандарт, хэм хэмжээнд хийсэн үнэлгээ..... 40

НЭР ТОМЬЁО

АХБ	Азийн Хөгжлийн Банк
МУУАЭ	Мөнгө Угаах Үйл Ажиллагааны Эсрэг
МУТАНДБ	Мөнгө Угаахтай тэмцэх Ази Номхон Далайн Бүлэг
ҮАБХШБҮЗ	Үр Ашигтай Банкны Хяналт Шалгалтын Базелийн Үндсэн Зарчим
МБ	Монголбанк
ӨХЗХ	Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа
ТБҮЦ	Төв Банкны Үнэт Цаас
ТСТ	Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх
БЗЗЗ	Банкны Зохистой Засаглалын Зарчим
ЗМС	Зээлийн Мэдээллийн Сан
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ССҮХ	Санхүүгийн Салбарын Үнэлгээний Хөтөлбөр
ССТБҮ	Санхүүгийн Системийн Тогтвортой Байдлын Үнэлгээ
СЭБҮ	Санхүүгийн Эрүүл Байдлын Үзүүлэлтүүд
ОУНББС	Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт
ОУСТС	Олон Улсын Санхүүгийн Тайлагналтын Стандарт
АХ	Алдагдлын хэмжээ
ЗБӨХ	Зээл, Бодит Өртгийн Харьцаа
БСХС	Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан
МСБ	Мөнгөний болон Сангийн бодлого дахь ил тод байдалыг хангах хэм хэмжээ: Мөнгөний бодлого
СЯ	Сангийн Яам
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллагаа
ЧЗ	Чанаргүй Зээл
ОСБ	Оролцогч Санхүүгийн Байгууллагууд
СХХТ	Стандарт, хэм хэмжээний тайлан
ТТБЦГ	Төлбөр тооцооны бодит цагийн горим
ХЗХ	Хадгаламж Зээлийн Хоршоо
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрүүд
ШБӨЗХ	Шударга Бус Өрсөлдөөнийг Зохицуулах Хороо
ХИЭХ	Хамгийн Их Эрсдлийн Хэмжээ

ХУРААНГУЙ

Монголын эрх баригчдын өмнө тавигдаж буй үндсэн зорилтын нэг нь эдийн засгийн тогтворгүй байдлаас үүсч болзошгүй эрсдэлтэй орчинд Монголын санхүүгийн салбарын хурдацтай өсөлтийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн системд хамааралтай хяналт шалгалтын болон зохицуулалтын тогтолцоог үргэлжлүүлэн сайжруулах явдал болно. Монголын санхүүгийн систем өнөөг хүртэл харьцангуй жижиг хэвээр байж зарим талаар хөгжлийн түвшин доогуур байгаа нь 1990-ээд оны сүүлчээр үүссэн банкны салбарын хэд хэдэн хямралын уршгийг даван туулахад цаг хугацаа нэлээд зарцуулсантай холбон тайлбарлаж болно. Эдийн засгийн дорвитой, тогтвортой өсөлтийг хангах үндсэн нөхцөл болох санхүүгийн системийг хөгжүүлэн бэхжүүлэхийг Монголын эрх баригчид стратеги зорилтуудынхаа гол цөм болгон тусгасан байна. Үнэхээр ч систем нь харьцангуй хоцронгуй явж ирснээ нийт эдийн засгийн хөгжил болон санхүүгийн салбарт хийгдсэн шинэчлэлийн дэмжлэгтэйгээр сүүлийн үед хурдацтай хөгжих боллоо.

Монголын санхүүгийн системийн тогтвортой байдлын төлөв ерөнхийдөө эерэг байгаа хэдий ч ирээдүйд үүсч болзошгүй зарим эрсдлүүдэд өртөх магадлал байна. Санхүүгийн эрүүл байдлын үзүүлэлтүүд (СЭБҮ) нь Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлттэй уялдан банкны салбарын эрүүл, бат бөх байдлын дүр зургийг илтгэнэ. Гэвч, өнгөрсөн жилийн хугацаанд зээлийн өрийн өсөлтөөс тодорхой хэмжээгээр өдөөгдсөн инфляцийн огцом өсөлт нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулах болов. Түүнээс гадна, Монгол улсын эдийн засаг экспортын бүтээгдэхүүний хязгаарлагдмал нэр төрөл, түүний нийлүүлэлтийн хэмжээ болон үнийн хэлбэлзлээс ихээхэн хараат байдаг нь банкны салбарын зээлийн чанар болон ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Цочролын сорилын үр дүн нь банкны системийн төлбөрийн чадварын үзүүлэлтүүд бүхэлдээ сайн байгаа хэдий ч нөгөө талаар маш хүчтэй цочрол үүсэх тохиолдолд өөрийн хөрөнгийг ихээр нэмэгдүүлэх шаардлага тулгарч болзошгүйг харуулав.

Системийн хэмжээнд хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо болон санхүүгийн системийн аюулгүйн сүлжээ сул байгаа нь аливаа шокыг сулруулах системийн чадварыг хязгаарлаж, улмаар системийн хэмжээнд үүсч болзошгүй боломжит хүндрэлийн хариуцлагыг эрх баригчдад үүрүүлж байна. Мөнгөний болон гадаад валютын захын үйл ажиллагаа хөгжлийн эхний шатандаа яваа нь мөнгөний бодлогын арга хэрэгслэлийг дамжуулах механизмын хүүгийн бүтцийн түвшинд нөлөөлөх үр ашигтай байдлыг хязгаарладаг. Эдгээр сул талуудыг арилгахгүй бол цаашид үүсч болзошгүй сөрөг шокоос үүсэх хүндрэлийг шийдвэрлэх хариуцлага нь хамгийн түрүүнд эрх баригчдад оногдохоор байна. Өнгөрсөн хугацаанд санхүүгийн салбарт үүсч байсан хүндрэлийг арилгахад эрх баригчдын хүчин чармайлт их байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Ирээдүйд, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хэд хэдэн шинэчлэлийг төлөвлөн хэрэгжүүлэх ажил хийгдэж байгаа боловч тэдгээрийн

амжилттай хэрэгжилтийг хангах үүднээс асуудлыг зөв тодорхойлох, ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг оновчтой тогтоох нь чухал байна. Зарим чухал салбарт (жишээлбэл, хууль эрх зүйн орчин, төлбөр тооцооны систем болон санхүүгийн дэд бүтцийн бусад асуудлууд зэрэг) хийгдэхээр төлөвлөсөн шинэчлэлийг түргэсгэх шаардлагатай. Үүнээс гадна, санхүүгийн салбарын хөгжлийг хангах Засгийн газрын хөтөлбөрүүд (Хөгжлийн банк үүсгэн байгуулах, цаашид орон сууцны санхүүжилтийг дэмжих бусад үйл ажиллагаа зэрэг)–ийг хэрэгжүүлэхдээ шударга бус өрсөлдөөн болон санхүүгийн салбарт үүсч болзошгүй бусад сөрөг нөлөөллийг бий болгох нөхцлийг бүрдүүлэхээс зайлсхийх хэрэгтэй.

Санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийн бас нэг хүчин зүйл нь хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах явдал мөн. Монголбанкнаас явуулдаг банкны салбарын хяналт шалгалт нь банкны салбарын хөгжлийн өнөөгийн түвшинд харьцангуй сайн тодорхойлогдсон, эрсдэлд чиглэгдсэн бүтэцтэй байна. Гэвч цаашид хяналт шалгалтын хэрэгжилт, ялангуяа банкуудын үйл ажиллагаа улам нарийсан хөгжихийн хэрээр тэдгээрийн хөрвөх чадварын болон ажиллагааны эрсдлийн хяналтыг илүүтэй сайжруулах орон зай байна. Мөн, хууль эрх зүйн болон хяналтын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд нэгдсэн хяналт шалгалтыг явуулах, банкны дээд шатны удирдлага, ТУЗ-ын гишүүдэд тавигдах ажлын туршлага болон мэргэжил боловсролд тавих шаардлагыг чангатгах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Харин үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй байгаа СЗХ-ны хувьд банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээл дээр хэрэгжүүлж буй хяналт шалгалтын үйл ажиллагаа нь банкны салбарын хяналт шалгалттай харьцуулахад сул байна. СЗХ-ны үйл ажиллагааг сайжруулахад СЗХ-ны чадавхийг нэмэгдүүлэх, үүний тулд боловсон хүчнийг сургах болон салбарын тоон мэдээлэлийг сайжруулахад илүү анхаарал тавих хэрэгтэй. Үүнээс гадна Монголбанк, СЗХ-ны хянан шалгагчдийн хууль эрх зүйн хамгаалалтын тогтолцоог сайжруулах шаардлагатай.

Санхүүгийн дэд бүтцийг шинэчлэх хэд хэдэн чухал алхамууд хийгдэж байгаа боловч цааш нь сайжруулах зарим арга хэмжээнүүдийг авах бололцоо байсаар байна. Төлбөр тооцооны бодит цагийн горимыг (ТТБЦГ) нэвтрүүлэх төслийн ажлыг аль болох түргэсгэх, цаашид банк хоорондын төлбөр тооцооны мэдээллийг давхар хуулбарлах системийг сайжруулах шаардлага бий. Монголбанкны зээлийн мэдээллийн санг боловсронгуй болгох төлөвлөгөөг банкууд дундын зээлийн мэдээллийн шинэ сан үүсгэх төлөвлөгөөтэй нягт уялдуулах нь зүйтэй.

Санхүүгийн байгууллагууд, Монголбанк болон бизнесийн секторын зохистой удирдлагын тогтолцоог цаашид улам сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй. Санхүүгийн байгууллагын зохистой удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг сайжруулах ажил хэрэгжилтийн шатандаа явагдаж, банкуудын ТУЗ-өөс банкны эрсдлийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон зөвлөмжийг Монголбанкнаас боловсруулжээ. Цаашид Монголбанкны Хяналтын зөвлөлд төв банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг хянахтай холбоотой үүрэг даалгаврыг хариуцуулах ижил тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй. Түүнчлэн, зохистой засаглалын хэрэгжилт ба олон улсын нягтлан бодох бүртгэлийн, аудитын

стандартуудыг сайжруулах асуудал дотоодын хөрөнгийн захыг хөгжихэд угтвар нөхцөл байх болно.

Монголд санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжирсаар байна. Засгийн газраас бичил, жижиг болон дунд үйлдвэрүүдийн хөгжилд чиглэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөхүүлэн дэмжих ажиллагааг үргэлжлүүлэн явуулах нь зүйтэй. Хэдийгээр хөдөө орон нутагт банкны үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн боловч банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа хот суурин газруудад төвлөрсөн хэвээр байна. Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх болон үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хэрэгжиж буй Засгийн газрын болон хандивлагчдын төслүүд нь хэрэгжилт дууссаны дараагаар зах зээлийн зарчмаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах бололцоотой байх дээр анхаарч ажиллах нь зүйтэй.

Монголын ССҮХ-ийн ажлын хэсгээс өгсөн үндсэн зөвлөмжийг Хайрцаг 1-т үзүүлээ.

Хайрцаг 1. Монгол улс: ССҮХ-аас өгсөн үндсэн зөвлөмж

Зорилго	Зөвлөмж болгож буй арга хэмжээ
<i>Богино хугацаанд (нэн тэргүүнд хэрэгжүүлэх)</i>	
Банк болон Банк бус санхүүгийн байгууллагын хяналт шалгалт	<ul style="list-style-type: none"> • Банкуудын хөрвөх чадвар болон үйл ажиллагааны эрсдлийн хяналт шалгалтыг сайжруулах (ҮАБХШБҮЗ, СХХТн Хавсралтаас үзнэ үү) • Банкны зээлийн чанарын нягт хяналтыг үргэлжлүүлэн тавих (¶6-7) • СЗХ-ны чадавхи, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх (¶27) • Банкны болон банкны бус санхүүгийн байгууллагын хянан шалгагчдыг хамгаалах эрх зүйн тогтолцоог нэвтрүүлэх (ҮАБХШБҮЗ, СХХТ)
Системийн хөрвөх чадвар ба аюулгүйн сүлжээ	<ul style="list-style-type: none"> • Системийн хөрвөх чадварын урьдчилсан төсөөлөл, түүний удирдлагыг сайжруулах (¶18-19) • Санхүүгийн салбарын хүндрэл үүсэх үед хэрэгжүүлэх эрсдэлийн төлөвлөлтийн ажиллагааг сайжруулах (¶29) • Зөв тодорхойлсон банкны хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх (¶29)
Эрх зүйн тогтолцоог сайжруулах	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн салбарын хөгжил, хяналт шалгалт (¶23-25), орон сууцны санхүүжилт (¶38)болон хөрөнгийн захын дэд бүтэцтэй (¶41) холбоотой зайлшгүй шаардлагатай хуулиудыг батлах
Төлбөрийн систем	<ul style="list-style-type: none"> • Одоогийн системд давхар хуулбарлах системийн зохицуулалтыг хангах (¶20) • Төлөвлөж буй ТТБЦГ-ыг нэвтрүүлэхтэй уялдан үүсч болзошгүй төлбөр тооцооны эрсдлийг удирдах заавар журмыг боловсруулах (¶20)
Зээлийн мэдээллийн сан	<ul style="list-style-type: none"> • Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, салбарын бусад оролцогчдоос санаачилж буй зээлийн мэдээллийн хувийн сан байгуулах ажилтай харилцан уялдаж ажиллах (¶21-22)
Орон сууцны санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Орон сууцны зээлийн дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагааг явуулах, үүний дотор үл хөдлөх хөрөнгийн эрхийн бүртгэлийн системийг сайжруулах (¶38)
Бичил зээл, ЖДҮ-ийн зээл	<ul style="list-style-type: none"> • Хандивлагчдын хөтөлбөрболон бичил болон жижиг дунд үйлдвэрийг санхүүжүүлэх сангийн зах зээлийн дундажаас доогуур түвшингийн хүүтэй эх үүсвэрээс хараат байх банкуудын хамаарлыг бууруулах (¶45)
<i>Дунд хугацаанд</i>	
Банкны хяналт шалгалт	<ul style="list-style-type: none"> • Нэгдсэн хяналт шалгалтыг албан ёсоор нэвтрүүлэх (ҮАБХШБҮЗ, СХХТ) • ШБӨЗХ-ы эрх мэдлийн хүрээ, чадавхийг сайжруулах (¶14)
Шудрага бус өрсөлдөөнийг зохицуулах хорооны (ШБӨЗХ) үйл ажиллагааг сайжруулах	<ul style="list-style-type: none"> • СЗХ-ы санхүүжилтийн одоогийн практик зохистой эсэхийг нягтлах (¶27)
СЗХ-ы үйл ажиллагааг сайжруулах	<ul style="list-style-type: none"> • Нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг олон улсын түвшинд хүргэн сайжруулах (¶33-34) • Компанийн зохистой засаглалыг сайжруулах (¶35)
Нягтлан бодох бүртгэл ба аудитын үйл ажиллагаа	
Хөрөнгийн зах зээлийн хөгжил	
Орон сууцны санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Харилцагчдийн талаарх мэдээлэл ил тод байх дүрмийг зээлдүүлэгчдэд тогтоох, үл хөдлөх хөрөнгийн агент болон үнэлээчдэд үнэлгээний аргачлал болон мэргэжлийн стандартыг тодорхойлон тогтоох (¶39)

I. САНХҮҮГИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, ҮҮСЧ БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛ¹

A. Бүтэц

1. Монголын санхүүгийн систем харьцангуй жижиг, энгийн боловч хурдацтай өсөж байна. Хөгжиж буй эдийн засагтай ихэнхи орнуудын адил Монголын санхүүгийн системд арилжааны банкууд давамгайлах байр суурийг эзэлж 2007 оны эцсийн байдлаар зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 16 банкны нийт актив хөрөнгө нь санхүүгийн салбарын нийт активын 95 хувийг бүрдүүлж байна (Хүснэгт 1). Банкны салбарын нийт актив хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 2003 онд 52 хувь байсан бол 2007 онд 87 орчим хувь болж өссөн бөгөөд энэ нь нэрлэсэн дүнгээр 4.3 дахин өссөн болохыг харуулж байна. Банкны салбарын ихэнхийг гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшиж байгаа боловч бусад шилжилтийн орнуудын санхүүгийн салбартай харьцуулахад эдгээр гадаад хөрөнгө оруулагчдын дийлэнх нь хөрөнгө оруулалтын компаниуд (институциональ хөрөнгө оруулагчид), чинээлэг хувь хүн болон харьцангуй жижиг бүсийн банкууд байна.

2. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж зээлийн хоршоод (ХЗХ) нь хэмжээ, хөгжлийн түвшингээр доогуур байна. Амьдралын бус даатгалын салбар Даатгалын тухай хууль шинээр батлагдсан 2004 оны эхээр хамгийн доод түвшнээс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хэдийгээр хөрөнгийн захын үнэлгээ өссөн боловч энэ нь цөөн тооны хувьцааны идэвхитэй арилжаа, үнийн өөрчлөлтөөр тодорхойлогдож байна. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны цөөн тооны томоохон компаниуд болон ХЗХ-д харьяалагдах салбартаа голлох үүргийг гүйцэтгэж байгаа нь саяхан дампуурсан хэдэн ХЗХ-дод Засгийн газраас дэмжлэг үзүүлэхийг шаардсан нийгмийн дарамтыг үүсгэж байснаас харж болно.

B. Макроэдийн засгийн орчинд оршиж буй эрсдэл

3. Монголын эдийн засаг сүүлийн жилүүдэд сайн үзүүлэлттэй байгаа хэдий ч хэт халалтын шинж тэмдгүүд илэрч байна. ДНБ-ийн бодит өсөлт 2002 оноос хойш дунджаар 7 хувьтай байсан нь Монгол улсын үйлдвэрлэдэг гол бүтээгдэхүүн ялангуяа зэс болон алтны дэлхийн зах зээл дээрх үнэ огцом өссөн, хэд хэдэн хатуу өвлийн хор уршгийн дараа мал аж ахуй сэргэсэнтэй холбоотой. Инфляцийн түвшин мөн тогтвортой буурч 2007 оны дундуур 6 хувьд хүрсэн бол түүнээс хойш хугацаанд хурдацтай өсч, энэ нь банкны зээлийн чанарыг бууруулж улмаар энэ нь санхүүгийн

¹ Тогтвортой байдлын үнэлгээг өгөхөд шаардагдах банкны салбарын мэдээллийн чанар болон олдоц хангалттай байлаа. Гэвч зарим нарийвчилсан дүн сорил хийхэд шаардлагатай, тухайлбал өрхийн болон аж ахуйн нэгжийн салбаруудын нэгдсэн нэгдсэн тайлан тэнцэл байхгүй байв. Банкны бус санхүүгийн байгууллагын талаарх мэдээлэл мөн хязгаарлагдмал байсан нь ихэнхдээ өнөөг хүртэл эдгээр байгууллагын санхүүгийн салбарт эзлэх байр суурь бага, банкны бус салбарын хяналт шалгалт бүрдээд удаагүй байгаатай холбоотой.

салбарын тогтвортой байдалд эрсдэл учруулж байна.² Нэг талаас мөнгөний бодлогын хэрэгслүүд бойжилтын шатандаа хэвээр байгаа , нөгөө талаас мөнгөний болон гадаад валютын захууд нимгэн байгаа нь мөнгөний хумих бодлогын зорилгыг хүндрүүлж байна.³

4. Монгол улс цөөн тооны экспортын бүтээгдэхүүн, түүний хэмжээ болон үнийн хэлбэлзлээс ихээхэн хамааралтай байгаа нь санхүүгийн тогтвортой байдлын эрсдлийн мөн нэг хүчин зүйл болж байна.⁴

- **Зэсийн үнэ ихээхэн буурах магадлал өндөр байна.** 2003 оноос хойш дэлхийн зах зээл дээрх зэсгийн үнэ огцом өсөхөд дэлхийн зэсийн эрэлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг Хятад улсын эдийн засгийн хүчтэй өсөлт ихээхэн нөлөө үзүүлээ. Зэсийн ирээдүйнүнээс үзэхэд зэсийн үнийн талаарх зах зээлийн хүлээлт ирэх цөөхөнжилийн хугацаанд аажим аажмаар буурах хандлага байна. Хэрвээ зэсгийн үнэ хүлээгдэж буй хэмжээгээр, ялангуяа энэ нь ирээдүйн үнээс тодорхойлж болох хүлээлтээс илүү хурдацтай буурвал, эдийн засгийн өсөлт улмаар банкны зээлийн багцад үзүүлэх сөрөг нөлөө өндөр байх болно.⁵
- **Цаг агаарын сөрөг үзэгдлүүд үе үе Монголд тохиолдох нь олонтой.** Өвлийн дундаж улирал нь харьцангуй урт, цаг агаарын хувьд хүндхэн болж өнгөрдөг бол зарим тохиолдолд ихээхэн бэрхшээл учруулдаг байна. 1999, 2000 онуудад зундаа ган болж, түүний уршгаар 2000, 2001 онуудад өвлийн улиралд хэт хүйтэрснээс хөдөө аж ахуйн салбарын голлох хэсгийг бүрдүүлдэг мал аж ахуйд (нийт малын толгойн дөрөвний нэг) ихээхэн хохирол учруулж байжээ. Энэ байдал дахин үүсвэл хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй .

5. Монгол улс түүхий эдийн экспортоос ихээхэн хамааралтай байдаг нь валютын ханшийн хэлбэлзэлийг ихээхэн нэмэгдүүлдэг. Экспортын өндөр өсөлтөөс үүссэн гадаад валютын нөөцийн өсөлттэй уялдаад америк доллартай харьцах төгрөгийн ханш сүүлийн үед тогтвортой байгаа боловч зэсийн үнэ болон хөдөө аж

² Инфляцийн өсөлтийн янз бүрийн шалтгаанд хийсэн сорилийг Дүрмийн 4-р заалтын хэлэлцүүлгээр гарсан Ажлын хэсгийн тайлангийн Хайрцаг 1-ээс үзнэ үү.

³ ССҮХ-ийн ажлын хэсгээс хойш ОУВС-гийн Мөнгө, хөрөнгийн захын газраас техник туслалцааны хоёр ажлын хэсэг ирж мөнгөний бодлогын хэрэгслийг сайжруулах, мөнгө болон гадаад валютын захын үйл ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тал дээр ажиллан зөвлөгөө өгсөн. Дараачийн ажлын хэсэг 2008 оны сүүлээр ирэхээр төлөвлөгдсөн байгаа.

⁴ Зэс үйлдвэрлэдэг компаниуд Монголын ДНБ-ийн тавны нэг орчмыг, Монголын нийт экспортын талаас илүү хувийг, улсын төсвийн орлогын дөрөвний нэг орчмыг бүрдүүлдэг. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлт ДНБ-ий тавны нэг орчмыг бүрдүүлдэг.

⁵ Хэдийгээр улсын төсвийн орлогыг хамгаалах зарим хэрэгслүүдийг бүрдүүлэхэд нэлээд урт цаг хугацаа шаардагдах боловч Засгийн газрын орлого зэсийн экспортоос ихээхэн хамааралтай байгаа нь зэсийн үнэ буурахад Загийн газрын зардал, улмаар бодит эдийн засаг буурах магадлал бий.

ахуйн экспорт гэнэт буурснаар төгрөгийн ханш сулрах сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг харуулж байна. Нөгөө талаас, Монгол улс уул уурхайн томоохон нөөцүүдээ ашиглах зорилгоор ихээхэн хэмжээний гадаад хөрөнгө оруулалтыг татах ажлыг хийгээд байгаа. Гадаадын хөрөнгө оруулагчдаас орох хөрөнгийн урсгал үргэлжлэн, төлөвлөсөн уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлснээр төгрөгийн ханшийг чангарах бодит магадлалыг бий болгож байна.

Хүснэгт 1. Монгол улс: Санхүүгийн системийн бүтэц, 2003-2007

	2003 оны 12 дугаар сар			2004 оны 12 дугаар сар			2005 оны 12 дугаар сар			2006 оны 12 дугаар сар			2007 оны 12 дугаар сар		
	Тоо	Актив (тэрбум төгрөг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төгрөг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төгрөг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төгрөг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төгрөг)	Нийт активт эзлэх хувь
Банк	17	767	97.6	17	892	92.2	17	1,371	97.3	16	1,899	94.7	16	3,279	95.7
Хувийн	16	16	16	16	1,899	94.7	16	3,279	95.7
Дотоод	6	967	28.2
Гадаад	10	2,312	67.5
Төрийн өмчийн	1	1	1	0	0	0.0	0	0	0.0
Банк бус санхүүгийн байгууллага	88	19	2.4	514	76	7.8	522	38	2.7	1,096	107	5.3	379	147	4.3
Даатгалын компани	19	22	1.1	15	28	0.8
Амь бус	0	0	0.0	0	0	0.0	0	0	0.0
Амь бус	0	0	0.0	0	0	0.0	0	0	0.0	19	22	1.1	15	28	0.8
Хадгаламж зээлийн хоршоод	0	0	0.0	400	47	4.9	400	955	16	0.8	192	36	1.0
Санхүүгийн компаниуд / ББСБД	88	19	2.4	114	29	3.0	122	38	2.7	122	69	3.4	137	66	1.9
Үнэт цаасны компаниуд / Брокеры	0	0	0.0	0	0	0.0	0	0	0.0	0	0	0.0	35	16	0.5
Нийт санхүүгийн систем	105	786	100.0	531	968	100.0	539	1,410	100.0	1,112	2,006	100.0	395	3,425	100.0

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо; болон ОУВС-гийн мэргэжилтнүүдийн тооцоолол

В. Санхүүгийн системийн үндсэн оролцогчид

6. Орон сууцны захын сүүлийн үеийн хөгжлийн хандлага, Монголчууд байр, орон сууцны нөхцлөө сайжруулах шаардлага өсөж байгаатай уялдан өрх гэрүүдэд олгосон орон сууцны зээлийн өрийн үлдэгдэл өсч байна. Энэ нь банкуудад зээлийн багцын төрөлжүүлэлтийг нэмэгдүүлэх давуу талыг олгож байгаа боловч эргээд үл хөдлөх хөрөнгийн үнийн эрсдэлд банкуудыг өртөмтгий болгож байна. Орон сууцны зориулалттай зээл олголт өсч, Монгол улсын дэд бүтэц сайжирч байгаатай уялдан барилгын салбар дахь зээлийн өсөлт мөн өндөр байна. Өнөөгийн байдлаар Монгол дахь үл хөдлөх хөрөнгийн салбарт олгож буй зээлийн үйл ажиллагаа харьцангуй эхлэлийн үе шатанд, ДНБ-д эзлэх орон сууцны зээлийн өрийн үлдэгдэл дөнгөж 3.5 хувь байгаа хэдий боловч Монголбанкнаас орон сууцны зээлийн олголт, энэ чиглэлийн зээлийн үйлчилгээний зохистой хяналтын асуудалд онцгой анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй.

7. Гадаад валютын ханшийн эрсдлээс хамгаалагдаагүй зээлдэгчдэд (гол төлөв компаниудад гэхдээ тодорхой хэмжээнд иргэдэд) олгосон гадаад валютын зээлийн өрийн үлдэгдэл буурч байгаа боловч харьцангуй өндөр түвшинд хэвээр байна. Гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ 2006 оны 12 дугаар сарын байдлаар нийт зээлийн 44 хувийг эзэлж байсан бол 2007 оны 10 дугаар сарын байдлаар 33 хувь болж, гадаад валютаар байршуулсан хадгаламжийн нийт банкны хадгаламжид эзлэх хэмжээ мөн хугацаанд 38 хувиас 34 хувь болон буурчээ. Гадаад валютаар олгосон зээлийн дийлэнхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зээл эзэлж байна. Аж ахуйн нэгжид гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ аж ахуйн нэгжид олгосон нийт зээлийн хэмжээний 50 гаруй хувийг эзэлж байгаа боловч, эдгээр зээлдэгч аж ахуйн нэгжийн заримынх нь үйл ажиллагаа гадаад валютаар илэрхийлэгдэх орлого байхгүй буюу хязгаарлагдмал байна. 2007 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар өрх бүлд олгосон гадаад валютын зээл өрх бүлд олгосон нийт зээлийн 12.9 хувийг эзэлж, энэ нь ДНБ-ний 2.1 хувьтай тэнцүү байлаа. Үүнээс үзэхэд, дотоодын зээлийн хүү гадаадын зээлийн хүүгийн нэрлэсэн түвшингээс мэдэгдэхүйц өндөр хэвээр байгаа цагт ханшийн эрсдлийн хамгаалалт хийгээгүй гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өсөх хандлагатай байсаар байх болно.

II. БАНКНЫ САЛБАРЫН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

А. Үр дүнгийн үзүүлэлтүүд

8. Банкны системийн Санхүүгийн эрүүл байдлын үзүүлэлтүүд (СЭБҮ) бүхэлдээ сайн байгаа дүр зургийг харуулж байна. (Хүснэгт 2 болон 3). Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт (ӨХЗХ) 2002 онд байсан 20 хувиас огцом буурч 2007 оны 12 дугаар сарын байдлаар 14 хувь болж буурсан хэдий ч энэ нь

зээлийн хэмжээ ихээхэн нэмэгдэж хөрөнгийн ашиглалтын үр ашиг сайжирсантай холбоотой.⁶ Үүнтэй адилаар, чанаргүй зээлийн (ЧЗ) хэмжээ харьцангуй доогуур түвшинд хүртэл буурчээ. Системийн дүнгээр өөрийн хөрөнгийн өгөөжийн (татварын дараах) дундаж үзүүлэлт 2002 онд байсан 21 хувиас 2006 онд 14 хувь болон буурсан боловч үүний дараагаар эргээд 2007 онд 21 хувь хүртэл ихээхэн өсчээ. Хэдийгээр ашигт ажиллагааны энэхүү өсөлт нь зээлийн хурдацтай өсөлтөөс ихээхэн шалтгаалсан боловч 2007 оны огцом өсөлтийн тодорхой хувийг томоохон арилжааны банкууд оффшор бүсээс хямд эх үүсвэр татаж зээлийн эх үүсвэрээ илүү төрөлжүүлсэнтэй мөн холбоотой.

⁶ Хэдийгээр ӨХЗХ-ны үзүүлэлтүүд харьцуулсан дүнгээр буурч байгаа боловч банкны систем өсөх тусам банкуудын өөрийн хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэж, ӨХЗХ-ний үзүүлэлтийг тогтмол ханган биелүүлж иржээ.

Хүснэгт 2. Монгол улс: Банкны салбарын эрүүл байдлын үндсэн үзүүлэлтүүд

	2002	2003	2004	2005	2006	2007
<i>Өөрийн хөрөнгийн хүрэлцээ</i>						
Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа	20.0	20.4	20.0	18.2	18.1	14.2
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа	17.7	18.5	17.4	15.8	15.6	11.9
<i>Активын бүтэц, чанар</i>						
Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ	5.0	4.7	6.0	5.6	4.7	3.2
Чанаргүй цэвэр зээлийг зээлийн нөөцөөр цэвэрлэсэн харьцаа	-1.0	0.0	0.7	0.2	2.5	2.4
<i>Зээлийн зориулалт салбараар (Нийт зээлд эзлэх хувиар)</i>						
Хөдөө аж ахуй, ан, ой, загасчлал	4.1	5.7	4.7	6.7	8.2	7.6
Эрчим хүч, уур болон усан хангамж	1.5	1.9	2.5	2.2	1.1	1.5
Барилга байгууламж	6.2	7.5	8.6	8.9	9.1	15.6
Уул уурхайн	15.4	8.4	8.6	9.0	7.8	6.3
Аж үйлдвэрлэл	24.2	20.1	18.7	16.2	12.9	13.0
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварын	30.8	34.0	34.6	33.2	31.0	29.2
Аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газар	1.7	1.8	2.0	2.1	1.6	1.3
Тээвэрлэлт, хадгалалт, харилцаа холбоо	2.9	3.0	2.8	4.3	4.2	1.7
Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн бизнесийн үйл ажиллагаа	1.1	2.2	2.6	2.4	2.5	2.5
Эрүүл мэнд, боловсрол	0.6	0.5	1.0	0.7	0.9	0.7
Санхүүгийн зуучлал	0.5	1.0	0.9	1.0	1.2	0.7
Бусад	11.0	13.8	13.1	13.2	19.2	19.8
<i>Ашигт ажиллагаа</i>						
Активын өгөөж (татварын дараах)	4.3	3.1	2.5	2.2	2.7	2.5
Өөрийн хөрөнгийн өгөөж (татварын дараах)	20.8	14.7	12.3	12.1	14.3	20.8
Хүүгийн зөрүү, нийт орлогын харьцаа	39.8	35.9	31.5	30.9	27.8	28.3
Хүүгийн бус зардал, нийт орлогын харьцаа	50.3	49.1	58.8	54.3	55.4	46.5
<i>Хөрвөх чадвар</i>						
Түргэн борлогдох актив, нийт активын харьцаа	39.9	35.3	31.6	36.0	37.9	28.1
Түргэн борлогдох актив, богино хугацаат эх үүсвэрийн харьцаа	0.0	83.5	28.8	37.7	38.2	37.0
Зээл, хадгаламжийн харьцаа	67.3	78.5	91.9	89.7	95.6	101.3
<i>Зах зээлийн эрсдлийн мэдрэмж</i>						
Цэвэр нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцаа	8.9	36.5	33.6	27.4	30.8	30.1

Эх сурвалж: Монголбанк

9. Гэвч санхүүгийн эрүүл байдлыг тодорхойлсон олон үзүүлэлтүүд нь өнгөрснийг харуулсан үзүүлэлтүүд байдаг. Ялангуяа, Монголд үүсч байгаа шиг зээлийн хурдацтай өсөлтийн ард чанаргүй зээлийн бодит өсөлт нуугдах явдал гардаг. Түүгээр барахгүй ихэнх зээлийн төлөгдөх хугацаа харьцангуй богино, банкны тэнцэлийн нийт дүн хурдацтай өсч буй үед хугацаа дууссан зээлийн хугацааг сунгаснаас үүсэх зээлийн чанарын бууралт тайлан тэнцэлд шууд харагдах боломжгүй байдаг. Үүнтэй уялдуулаад, Монголбанкнаас газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалтыг тогтмол эрчимтэй хийж байгаа бөгөөд үүний үр дүнд зээлийн чанар сайжирч байгаа итгэлбайна.

10. Санхүүгийн салбар гүнзгийрэн хөгжихөд зээлийн хурдацтай өсөлт нөлөө үзүүлсэн. Нэг талаас эдийн засагт төсвийн тэлэлтийн хүчтэй нөлөөлөл, нөгөө талаас эдийн засагт ажиглагдаж буй хэт халалтын шинж тэмдгүүдээс харахад зээлийн чанар сайжирсаар байгаад бүрэн итгэх итгэлийг төрүүлж чадахгүй байна. Санхүүгийн систем гүнзгийрэн хөгжих нь аль ч тохиолдолд макро-санхүүгийн уялдааг бэхжүүлж улмаар банкны салбарт шинэ төрлийн эрсдлүүдийг үүсгэдэг.

11. Хэдийгээр Монголын банкуудын гадаад эх үүсвэрээс хамаарах хамаарал харьцангуй бага боловч түүний өсөх хандлага нь ирээдүйд сул тал үүсгэнэ. Банкны системийн нийт зээл, хадгаламжийн харьцаа нэгтэй ойролцоо (Хүснэгт 2) байгаа нь банкуудын анхдагч эх үүсвэр нь дотоодын хадгаламж хэвээр байгааг үзүүлж байгаа боловч өнгөрсөн хоёр жилийн турш энэхүү харьцаа нь өсч байна. Төв болон Зүүн Европын хэд хэдэн банкны системийн жишээнээс үзэхэд эдгээр улсын банкууд гадаад эх үүсвэрээс ихээхэн хамааралтай байдаг нь гадаад хөрөнгө оруулагчид улс орны эрсдэлийг тухайн улс болон бусад улсад болж буй хүчин зүйлээс хамааруулан дахин үнэлэхэд хүргэж улмаар гадаад эх үүсвэрийг ихээхэн хязгаарлахад хүргэж, банкуудыг хөрвөх чадварын эрсдэлд учруулдаг тохиолдлууд байсаар байна.

12. Хэдийгээр банкны системийн үзүүлэлт бүхэлдээ сайн байгаа боловч банк тус бүрийн үзүүлэлт нь их хэмжээгээр өөр хоорондоо ялгаатай, жижиг банкуудын үзүүлэлт дундажаас доогуур түвшинд байна. Одоогийн байдлаар хамгийн том 4 банкны ашигт ажиллагаа маш сайн байна. Харин жижиг банкуудын ашигт ажиллагаа доогуур бөгөөд зарим банкууд эдийн засгийн өндөр өсөлттэй өнөөгийн нөхцөлд алдагдалтай ажилласаар байна. Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ ч мөн банк бүрээр ялгаатай бөгөөд 4 том банкны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 5 жижиг банкны үзүүлэлттэй харьцуулахад хамаагүй бага байна. Монголбанкнаас банкуудын зээлийн чанарыг эрчимтэй хянаж байгаатай уялдаад тухайн банкны үйл ажиллагааг ерөнхий байдлаар нь нарийн хянаж байна. Үйл ажиллагааны үр дүн харьцангуй сул байгаа банкууд нь бүгд жижиг банкны бүлэгт хамаарч байгаа тул эдгээрээс үүсч болзошгүй эрсдэл системийн гэхээс илүү Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагааны буюу нэр хүндийн асуудал болохыг үзүүлж байна.

13. Хүүгийн түвшин, Монголын томоохон банкуудын ашигт ажиллагааны түвшин өндөр хэвээр байгаа хэдий ч банкны системийн өрсөлдөөн ерөнхийдөө сайн байна. Монголын хадгаламжийн хүү өндөр хэвээр байгаа боловч шилдэг харилцагчийн төлөө банкуудын өрсөлдөөн зээлийн хүүгийн түвшин, зээл болон хадгаламжийн хүүгийн зөрүүг бууруулж, тус үзүүлэлтийг ижил төстэй улс орнуудын түвшинд хүргэжээ. Хадгаламжийн хүү өндөр хэвээр хадгалагдсаар байгаа нь инфляцийн өндөр хүлээлт, 1990-ээс оны сүүлчээр болж өнгөрсөн банкны хямралаас хойш итгэлцэл аажмаар үүсч байгаагийн үр дүн байх магадлалтай. Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах хороо (ШБӨЗХ)-ноос тодорхойлсоноор, банкууд хоорондоо үгсэж, хүүг хүчээр барьж байгаа зүйл илрээгүй бөгөөд банкуудын хооронд шилжих хадгаламжийн хөдөлгөөн хангалттай өндөр түвшинд байна гэж үзжээ.⁷

14. Иймд, Монголын санхүүгийн байгууллагууд хоорондын өрсөлдөөнийг тодорхой зарим чиглэлээр улам нэмэгдүүлэх орон зай бий. Зарим банкууд хөдөө орон нутаг дахь өөрийн тодорхой давамгайлсан нөхцөл байдлыг ашиглан харьцангуй өндөр үйлчилгээний хураамж авч байгаа бөгөөд зуучлалын дундаж зөрүүнд хийсэн шинжилгээнээс үзэхэд хөдөө орон нутаг дахь хүүгийн зөрүү нь хотууд дахь хүүгийн зөрүүнээс өндөр байгааг харуулж байна. Өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх дараагийн алхам нь одоогоор харьцангуй хязгаарлагдмал байгаа ШБӨЗХ-ны эрх мэдэл болон чадавхийг бэхжүүлэн сайжруулах явдал юм. Ирээдүйд өрсөлдөөн нэмэгдсэнээр, банкуудын ашигт ажиллагаа хумигдаж банкны салбарт нийлж/нэгдэх үйл явц ажиглагдах магадлалтай.

Б. Цочролын сорил

15. ССҮХ-ийн ажлын хэсгээс Монголбанкны ажилтнуудтай хамтран хэд хэдэн цочролын сорилыг боловсруулж гүйцэтгэлээ. (Хавсралт 1). Сорилд мэдрэмтгий байдлын болон орчны өөрчлөлтийн шинжилгээ хоёул багтсан. Шокын далайцыг үзүүлэлт тухайн бүрийн (зээлийн, хүүгийн болон ханшийн эрсдлүүд) түүхэн болон таамаглаж буй өөрчлөлттэй уялдуулан сонгосон. Орчны сорилд ашигласан нэг дэх нөхцлөөр гадаад орчноос үүсч болзошгүй сөрөг шокын таамаглал дэвшүүлсэн бол хоёр дахь нөхцөлөөр хөрөнгийн их хэмжээний гадаадаас орж ирэх урсгалыг төсөөлсөн болно. Монголын банкны системийн төлбөрийн чадварын эрсдэл харьцангуй бага гэж үзсэний улмаас төлбөрийн чадварын эрсдэл (дотоод болон үндэстэн дамнасан хоёул)-ийг сорилд хамруулаагүй болно. Банкуудын актив харьцангуй богино хугацаатай байгаа нь актив, пассивын хугацааны зөрүү харьцангуй бага, гадаад санхүүжилтийн эх үүсвэрээс хамаарах хамаарал бага байгааг үзүүлж байна.

⁷ 2005 оны 1-р сард үүсгэн байгуулагдсан Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах хороо нь банкны салбарыг оролцуулаад эдийн засгийн бүх л салбарын өрсөлдөөнийг хэмжих, харилцагчдад түгээх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашгийг сайжруулах зорилготойгоор ажиллаж байна.

16. ССҮХ-ын ажлын хэсгээс хийж гүйцэтгэсэн цочролын сорилоос үзэхэд аливаа нөхцөл, шок үүсэх тохиолдолд банкны системийн ерөнхий өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт зохистой түвшинд хэвээр үлдэх боловч маш хүчтэй сөрөг шокын үед зарим банкуудад ихээхэн хэмжээний нэмэлт өөрийн хөрөнгө шаардлагатай болно. Систем бүхэлдээ уян хатан байгаа нь олон хүчин зүйлсээс хамааралтай байна. Үүнд: ихэнх банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайн, активын чанар өндөр бөгөөд сайжрах хандлагатай, ханшийн эрсдлээс өөрсдийгөө хамгаалаагүй зээлдэгчдэд олгосон гадаад валютын зээлийн хэмжээ бага бөгөөд банкны зээлийн багцын дундаж хугацаа харьцангуй богино зэрэг болно. Харин зээлийн багцын чанараас үүсэх хүчтэй эрсдэл л системийг бүхэлд нь хамарсан шокыг авчирч болзошгүй юм. Жишээлбэл, дэлхийн зах зээл дээрхи зэсийн үнэ буурч улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд удаашрал учрах нөхцөлд банкны системийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 15 орчим хувиас Монголбанкнаас доод хэмжээ болгон тодорхойлсон 10 хувийн шаардлагын түвшингээс яльгүй өндөр түвшин хүртэл буурахаар байна (Хавсралт 1, Хүснэгт 4). Үүнтэй адилаар, үзүүлэлт бүрээр хийсэн сорилын дүнгээс үзэхэд, чанаргүй зээлийн нийт зээлтэй харьцах харьцаа 10 нэгж хувь буюу их хэмжээгээр өсөх таамаг дэвшүүлэхэд, системийн нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 9.8 хувь болж буурахаар байна.

17. Банк бүрийн тайлан тэнцлийн бүтэц хоорондоо ихээхэн ялгаатай байгаа нь цочролын сорилын үр дүн системийн хэмжээнд ихээхэн зөрүүтэй байх нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал, зарим шокын нөлөөнд системд томоохон байр суурь эзлэх банкууд системийн дундажтай харьцуулахад ихээхэн далайцтайгаар өртөхөөр байна. Жишээлбэл, цаг агаарын хүнд байдлаас хөдөө аж ахуйн салбарт үүсч болзошгүй сөрөг шокын нөлөөллийг судлахад том банкуудын бүлгийн дундаж өөрийн хөрөнгийн үзүүлэлт 8.5 орчим хувь болж буурах, чанаргүй зээлийн нийт зээлд харьцуулсан харьцаа 10 нэгж хувиар өсөхөд том банкуудын бүлгийн дундаж өөрийн хөрөнгийн үзүүлэлт 7 хувиас яльгүй бага хувь болон буурахаар байна. Дэлхийн зэсийн үнэ буурахыг таамагласан шокын нөлөө эдгээр том банкны бүлгийн нэгдсэн үзүүлэлтэд мөн л ижил их байхаар байна. Харин эсрэгээрээ, ихэнх нь хөрөнгө оруулалтын банкны шинжтэй үйл ажиллагаа явуулдаг жижиг банкуудын бүлэг эдгээр цочролын сорилд таамагласан шокын нөлөөнд харьцангуй бага автахаар байна.

В. Системийн хөрвөх чадвар

18. Системийн хөрвөх чадварын удирдлага нь мөнгө, гадаад валют болон үнэт цаасны захуудад хийгдэх харьцангуй жижиг гүйлгээнүүд болон хэлбэлзэл өндөртэй мөнгөн урсгал (ялангуяа Сангийн яам (СЯ)-ны төрийн сангийн данс болон банкны системийн хоорондох гүйлгээ, шилжүүлэг)-аар хязгаарлагдаж байна. Төв банкны нэг долоо хоногийн хугацаатай үнэт цаас (ТБҮЦ) 2000 оны эхэн үеэс зах зээл дээр гарсан боловч Монголбанк 2007 оны 7 дугаар сараас хойш мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх шинэ тогтолцоонд шилжсэнтэй уялдуулан банкны системийн хөрвөх чадварыг удирдах үндсэн хэрэгсэлээ болгожээ. Энэхүү өөрчлөлтөөс хойш

ТБҮЦ-ны хэдхэн тооны арилжаа хийгдсэн бөгөөд зах зээлийн оролцогчид бодлогын шинэ тогтолцоонд өөрийн үйл ажиллагааг тохируулах завсрын үе шатанд явна. Үүнээс гадна, Монголбанкнаас мөнгөн гүйлгээний урсгалыг урьдчилан таамаглах боломж хязгаарлагдмал, зарим урсгалын, тэр дундаа СЭЗЯ-ны орлого зарлагын урсгалын хэлбэлзэл өсч, урьдчилан таамаглах боломжгүй болсонтой холбоотой байна. Эдгээр хязгаарлагдмал байдал нь эрх баригчдаас хэрэгжүүлэх хөрвөх чадварын удирдлага, санхүүгийн системийн шокиг даван гарах ажиллагаанд хүндрэл учруулах талтай.

19. Хөрвөх чадварын үр ашигтай удирдлагыг сайжруулахад холбогдох захуудын хөгжил зайлшгүй бөгөөд энэ нь цаг хугацааг шаардах боловч тэр болтол тодорхой арга хэмжээнүүдийг авч болно. Монголбанкнаас урт хугацааны ТБҮЦ-ийг гаргах, 12 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжаа явагдах давтамжийг олшруулах зэргээр үнэт цаасны захыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнээс гадна, ТБҮЦ-аар бүрэн барьцаалсан нөхцөлтэй Монголбанкны мөнгөний бодлогын өнөөгийн зарим хэрэгслүүдийг халж, Монголбанкнаас хөрвөх чадварыг урьдчилан таамаглах чадварыг СЭЗЯ-наас төрийн сангийн дансны гүйлгээний талаарх урьдчилсан мэдээлэл авах зэргээр сайжруулах арга хэмжээ авч болно.

Г. Санхүүгийн системийн дэд бүтэц

Банк хоорондын төлбөр тооцооны систем

20. Санхүүгийн системийн дэд бүтцийг бэхжүүлэн сайжруулах зорилгоор өнөөгийн төлбөр тооцооны системийг шинэчлэх төлөвлөгөөг Монголбанк гаргаад ажиллаж байна. Банк хоорондын төлбөр тооцооны системээр дамжуулан хийдэг гүйлгээний дүн болон тоо хэмжээ нь тогтвортой өсчээ. Одоогоор харьцангуй бага хэвээр боловч бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэлийг төлбөр тооцоонд ашиглах явдал өссөөр байна. 2008 онд төлбөрийн системийн эрсдлийг бууруулах зорилгоор өндөр дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны бодит цагийн горим (ТТБЦГ)-ийг нэвтрүүлснээр тухайн өдрийн эцэст цэвэршүүлэн төлбөр тооцоо гүйцэтгэх одоогийн системийг халах төлөвлөгөөтэй байна. Мөн картын төлбөр тооцоонд банк бүр тусдаа системийг ашигладагийг болиулж картын төлбөр тооцооны нэгдсэн системийг нэвтрүүлэхээр шийдвэрлэжээ. Цаашид, төлбөр тооцооны системийг өргөжүүлэх чиглэлээр дараах өөрчлөлт шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Төлбөр тооцооны эрсдлийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк бусад банкуудтай харилцан тохиролцсоны үндсэн дээр өдрийн турш хөрвөх чадварын хэрэгцээг нөхөх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай. Хэдийгээр өнөөгийн байдлаар ашиглаж буй өдрийн эцсийн цэвэр дүнгээр тооцдог төлбөр тооцооны систем журмаараа, сайн ажиллаж байгаа боловч төлбөр тооцооны бодит цагийн горимд шилжсэнээр банкууд өдрийн турш эх үүсвэр дутагдах хүндрэлд орж болзошгүй.

- Төлбөр тооцооны системийн архитектурыг сайжруулан, үйл ажиллагааг зогсолтгүй үргэлжлүүлэх стратеги боловсруулах шаардлагатай. Тухайлбал, системийн одоогийн бүтцийн хүрээнд банк хоорондын төлбөр тооцоонд оролцогч гишүүдэд үндсэн систем удаан хугацаагаар хаагдсан эсвэл ажиллагаагүй болох нөхцөл үүсэхэд хуулбарлан хадгалах төвтэй шууд холбогдох гарцыг зааж өгөөгүй. Хэрвээ энэ нөхцөл байдал үүсвэл банкны системийн түвшинд банк хоорондын төлбөр тооцоо зогсоход хүрнэ.
- Монголбанкнаас банк хоорондын төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийн програм болон төв банкны үйл ажиллагааны санхүүгийн бүртгэл, тайлан мэдээний програмыг сайжруулах хэрэгтэй. Монголбанкны одоогоор ашиглаж байгаа, дотооддоо боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн програм нь өсч буй ирээдүйн гүйлгээний эргэлтийг хангахад хүчин чадлын хувьд хүрэлцэхгүй байх магадлалтай.

Зээлийн мэдээллийн сан

21. Монголбанкны Зээлийн мэдээллийн сан (ЗМС)-гийн үйл ажиллагааг салбарын өнөөгийн шаардлагад нийцүүлэн хэд хэдэн чиглэлээр сайжруулах шаардлагатай.⁸ Зээлдэгч нэг бүрээр зээлийн нэгдсэн мэдээллийг гаргах замаар мэдээллийн хамрах хүрээ, чанарыг сайжруулах шаардлагатай. Салбарын байгууллагууд болон Монголбанкны бусад газар хэлтэстэй зөвлөлдсөний үндсэн дээр цуглуулж буй мэдээллийн төрлийн хүрээг өргөсгөх, тайлангийн загварыг сайжруулах хэрэгтэй.

22. Салбарын хурдацтай өсөлт болон үйл ажиллагааны төрөлжүүлэлттэй уялдан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахад ЗМС-ийн чадвар хязгаарлагдмал нь зарим банкууд зээлийн мэдээллийн хараат бус хувийн санг бие даан бүрдүүлэх төслийг санаачлахад хүргэжээ. Үйл ажиллагаа явуулж буй одоогийн ЗМС болон салбарын бусад оролцогчдоос шинээр байгуулахаар санаачилсан хувийн мэдээллийн сан хоорондын зохистой уялдаа, хамтын ажиллагаа нь хяналт шалгалтын болон салбарын шаардлагыг үр ашигтай биелүүлэх тэрхүү мэдээллийн системийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хууль эрх зүйн тогтолцоо

23. Хэдийгээр хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах тал дээр дорвитой алхамуудыг ялангуяа банкны салбарт тулгарсан 1990-ээд оны сүүлчийн

⁸ ЗМС нь 1997 онд үүсгэн байгуулагдсан зээлийн мэдээллийг бүртгэдэг улсын нэгж юм. Бүх л банкууд өөрсдийн олгосон нэг сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн талаарх мэдээг тогтмол давтамжтайгаар ЗМС-нд хүргүүлдэг. ЗМС-ийн зорилго нь банкууд болон томоохон ББСБ-уудад зээлийн өргөдлийг хянах хүрээнд тухайн зээлдэгчийн зээлийн түүх, өнөөгийн байдлыг шалгах хэрэгсэл болоход оршдог.

хүндрэлтэй холбогдуулж хийсэн хэдий ч өнөөгийн хууль эрх зүйн тогтолцоо нь хэд хэдэн чиглэлээр сул хэвээр байгаа бөгөөд санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг хангах үүднээс эдгээрийг анхаарч шийдвэрлэх шаардлага байна. Шинээр гаргах зайлшгүй шаардлагатай хэд хэдэн хуулийн төслийг боловсруулсан тул цаашид засгийн газраас тэдгээрийг батлах ажиллагааг түргэвчлэх нь зүйтэй. Эдгээрт дараах хуулиуд багтаж байна. Үүнд : (i) шинэчлэн найруулсан банкны тухай хууль, (ii) шинэчлэн найруулсан үнэт цаасны тухай хууль, (iii) Орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн тухай хуулийн төсөл болон (iv) Орон сууцаар барьцаалсан үнэт цаас гаргах тухай хуулийн төсөл зэрэг болно.

24. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй зарим хуулиудад өөрчлөлт оруулах шаардлага байна. Үүний нэг жишээ нь Компанийн тухай хууль юм. Цөөнхийн сонирхлын талаарх компаниудын хүлээж буй үүрэг, хариуцлагын хэм хэмжээг зохистой түвшинд тодорхойлогдоогүй бөгөөд үүргээ биелүүлэхгүй тохиолдолд ногдуулж буй хариуцлагын арга хэмжээ нь үүргээ зайлшгүй биелүүлэх хангалттай нөхцөл болж чадахгүй байна. Эдгээр байдал нь Монголын хөрөнгийн захын хөгжлийг хойш нь татаж байна. Үүнээс гадна, Компанийн тухай хуулиар компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хараат бус гадны гишүүнийг ажиллуулах шаардлага алга. Дампуурлын тухай хууль 1996 онд батлагдаж, түүнээс хойш цөөн тооны хэрэг шийдвэрлэгдэж байсан бөгөөд хэрэг шийдвэрлэх ажиллагаа удаан бөгөөд төвөгтэй явагддаг байна.

III. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО

A. Хяналт шалгалт болон зохицуулалтын тогтолцоо

Арилжааны банкууд

25. Үр Ашигтай Банкны Хяналт Шалгалтын талаарх Базелийн Үндсэн Зарчмуудаар (ҮАБХШБҮЗ) явуулсан шалгалтын дүнд шилжилтийн үеийн ижил түвшинд байгаа бусад орнуудтай харьцуулахад Монгол улсын банкны хяналт шалгалт харьцангуй сайн хөгжсөн гэж үнэлэхээр байна. Монголбанк зайлшгүй шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнүүдийг бэлтгэж, банкуудад хийгдэх хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэсэн тогтолцоонд чиглүүлж байгаа нь ҮАБХШБҮЗ-тай ихээхэн нийцнэ. Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцооны хоорондох зөрүүтэй асуудлуудын тоонд нэгдсэн хяналт шалгалтыг явуулах эрх зүйн баримт бичиг байхгүй байгаа асуудал орно. Гэвч энэ төдийлөн том асуудал биш, цаг хугацааны хувьд шийдэгдэх боломжтой гэж үзлээ. Монголбанкны хянан шалгагч нарын ажил үүргээ хэрэгжүүлэх таатай нөхцлийг хангах хууль эрх зүйн орчин, тэдгээрийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, банкны удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах ажлын туршлага болон мэргэжлийн шалгуурыг чангатгах, “холбогдох этгээд”-ийн талаарх хуулийн тодорхойлолтыг том зээлдэгчид

хамаарах эрсдэлтэй активын багцыг шалгахад дөхөмтэй болгох зорилгоор өөрчлөн найруулах шаардлагабайна (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү).

26. Эрсдлийг тодорхойлж түүнийгээ удирдах болон зохистой харьцааг хангаж ажиллахыг банкны удирдлагуудаас Монголбанк шаарддаг. Зах зээлийн болон зээлийн эрсдлийн үнэлгээ, тайлангийн тогтолцоо бүрджээ. Харин ҮЙХШБҮЗ-ыг үнэлэх явцад Монголбанкнаас хөрвөх чадварын эрсдлийн журмыг хараахан гаргаагүй байв. Мөн түүнчлэн, банкинд ноогдуулах торгуулийн дээд хязгаарын бодит үнэлгээ инфляцийн нөлөөгөөр буурч үр ашигтай шийтгэврийн хэрэгсэл болж чадахгүй байна.

Банк-бус болон хөрөнгийн зах зээл

27. Банк-бус болон хөрөнгийн зах зээлд тавих хяналт шалгалтын тогтолцоог ихээхэн сайжруулах шаардлага байна. Ялангуяа, СЗХ-д боловсон хүчин, мэргэжлийн түвшин болон санхүүжилтын байдлыг дээшлүүлэх хэрэгтэй. Дөнгөж 2006 онд шинээр үүсгэн байгуулагдсан СЗХ нь нийтдээ 400 орчим байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд банкны бус санхүүгийн салбарын талаарх ойлголтыг дээшлүүлэх, хувьцаа эзэмшигчидтэй зохистой харилцааг тогтоох, өөрийн байгууллагын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхээр чармайн ажиллаж байна. (Хадгаламж зээлийн хоршоодын хяналт шалгалтын талаар Хавсралт 2-оос үзнэ үү). Тухайн салбарын бодит хэрэгцээ болон ижил, төстэй эрх бүхий байгууллагуудын олон улсын туршлагыг судлаж боловсон хүчнээ бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх нь ихээхэн ач холбогдолтой. Сургалтыг, ялангуяа гадаадын өндөр туршлага хуримтлуулсан зохицуулах шатны байгууллагатай хамтран хийх нь нэн тэргүүний чухал зүйл юм. Засгийн газраас СЗХ-нд хуваарилах санхүүжилтийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй. Хэдийгээр зохицуулах дээд шатны байгууллага нь зохицуулдаг пүүс, компаниудад ногдуулсан хураамжаар хэсэгчлэн буюу бүрэн санхүүжигдэх нь түүний хараат бус үйл ажиллагааг хангах давуу талыг бий болгодог ч Монголын өнөөгийн санхүүгийн салбарын хөгжлийн түвшинд банкны бус санхүүгийн салбар нь өөрийн бизнесийн үйл ажиллагаанд энэхүү нэмэлт татварыг үүрэх чадамжгүй байж болох талтай.

28. ББСБТХуулийг журамлах гэхээсээ илүү боломж олгосон байдлаар тусгасан өөрчлөх шаардлагатай. СЗХ-ны хувьд ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, үзүүлэлтүүд, тэдгээрийн давуу болон сул талуудаар сайн ойлголттой болсноор шинэчилсэн хууль боловсруулахад хялбар болох юм⁹.

⁹ СЗХ өөрийн ажилтнууд болон салбарын оролцогч нарт шаардлагатай сургалтыг явуулж байх сургалтын төвийг нээн ажиллуулахыг зорьж байна. Сургалтын зардал болон шаардагдах техник хэрэгслэлийг Монголбанк болон Банкуудын холбоотой хамтран гаргах хэлбэр байж болно.

Б. Санхүүгийн системийн аюулгүйн сүлжээ

29. Санхүүгийн аюулгүй байдлын сүлжээг бэхжүүлэх боломж байна. Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн үйл ажиллагааны хэрэгслүүд нь боломжийн зохистой гэж үзэж байна. Өнөөг хүртэл банкны систем нь хөрвөх чадвар сайтай байсан тул энэхүү хэрэгслэлүүдийг цөөн тохиолдолд л ашиглаж байжээ. Үүнийг илүү үр ашигтай болгох боломж бий. Мөн түүнчлэн, хэдийгээр Монгол улс дэлхийн санхүүгийн системд эзлэх байр суурь бага учраас 2007 оны дундаас эхэлсэн дэлхийн санхүүгийн зах зээлийн сөрөг нөлөөнд өртөөгүй боловч ирээдүйд учирч болзошгүй бэрхшээлүүдийг харгалзан эрсдэлийн нэмэлт төлөвлөгөөг нэн тэргүүнд боловсруулах нь чухал. Банкны систем дэх өрсөлдөөн нэмэгдсэнээр банкуудын ашиг буурах хандлагатай байгаа нь Монголбанкнаас эх үүсвэр дутагдах буюу хөрвөх болон төлбөрийн чадварын асуудалд орж болзошгүй аливаа банкинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нарийн төлөвлөгөөтэй байх нь хамгийн ач холбогдолтой байж болох юм. Санхүүгийн систем илүү нарийсахын хирээр шинээр үүсгэн байгуулагдсан Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл нь эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэх бололцоотой.¹⁰ Эрх баригч байгууллага банкуудад хадгаламжийн даатгалыг нэвтрүүлэх төлөвлөгөөгөө цаг алдалгүй хэрэгжүүлэх нь чухал.¹¹

В. Мөнгөний бодлогын ил тод байдал болон Төв банкны зохистой удирдлага

30. Мөнгөний бодлогын ил тод байдал нь ерөнхийдөө сайн боловч Монголбанкны зохистой удирдлага, ялангуяа Монголбанкны ерөнхийлөгчийн тайлагнах асуудлыг чангатгах нь зүйтэй. Төв банкны мөнгөний бодлогын ил тод байдал болон зохистой удирдлагын олон улсын туршлагын хүрээнд Төв банкны тухай хуульд Монголбанк болон түүний ерөнхийлөгчийн гаргасан шийдвэрт нэн ялангуяа, санхүүгийн буюу бусад эрсдлийг нэмэгдүүлэх Монголбанкны үйл ажиллагаанд Хяналтын Зөвлөлөөс тавих хяналтын эрх мэдлийг нэмэгдүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулах шаардлагатай. Төв банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хүлээлгүйгээр Хяналтын Зөвлөл нь Төв банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээ нийтлэх

¹⁰ Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлийг 2007 оны 6 сард Монголбанк, Сангийн Яам болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос үүсгэн байгуулжээ. Энэхүү зөвлөлийн үйл ажиллагааны зорилгыг санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, эдгээр гурван байгууллагын үйл ажиллагааны хүрэн дэх хамтын ажиллагааг сайжруулах, системийн эрсдлийг хянах гэж тодорхойлжээ.

¹¹ Хадгаламжийн даатгалын тухай хууль Улсын их хурлаар хэлэлцэгдэх шатандаа яваа. Хуулийн төслөөр даатгалын сан нь урьдчилан санхүүжигдэх бөгөөд бүх арилжааны банкууд нь зайлшгүй хамрагдах байдлаар тусгагдсан. Даатгалын хураамжийг банкны нийт хадгаламжийн үлдэгдэлд улиралд тогтмол 0.08 хувиар ногдуулж 1.5 сая төгрөг (1,268 ам.доллар буюу 2007 оны нэг хүн амд ноогдох ДНБ-ний 80 хувь орчим) хүртэлх дүнтэй иргэдийн хадгаламжыг нөхөхөөр тооцоолжээ. Мөн түүнчлэн, хямралын үед Засгийн газраас хийгдэх яаралтай санхүүжилтын талаар заасан байна.

замаар Монголбанкны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж болно. Тухайлбал, Хяналтын Зөвлөлөөс Монголбанкны үйл ажиллагааны талаарх Улсын Их хуралд хүргүүлдэг тайланг дэлгэрэнгүй эсхүл хураангуйлсан хэлбэрээр Монголбанкны жилийн тайланд тусгаж болох юм. Үүргээ өндөр түвшинд хэрэгжүүлэх үүднээс Хяналтын Зөвлөл нь санхүүгийн салбарын бодлого, практикийн арвин туршлага бүхий илүү олон тооны гишүүдээс бүрдсэн байх хэрэгтэй.

31. Монголбанкны удирдлага нь бодлогын эрсдэл болон өөрийн тайлан тэнцлийг тодорхойлж, удирдахад хэрэгжүүлж буй бодлого, ажиллагааны талаарх нэмэлт мэдээллийг нийтэд толиулж ил тод байдлыг нэмэгдүүлж болно. Тухайлбал, Гадаад валютын нөөцийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр өссч буй гадаад валютын нөөцийн хөрөнгө оруулалтын гүйлгээнд үүсч болзошгүй эрсдлийг хязгаарлах зорилгоор Монголбанк хэрэгжүүлж буй дотоодын журмаа нийтэд мэдээлж болно.¹²

Г. Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг/Терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУҮАЭ/ТСТ) ажлын хүрээнд

32. Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон Далайн Бүлгийн (АНДБ) Монголд хийсэн сүүлчийн үнэлгээгээр банкинд тавигдах зохистой үзүүлэлтийн шаардлагад нийцүүлсэн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр томоохон алхамууд хийгдсэн гэж дүгнэж харин банк бус салбарын хувьд гарсан дэвшилийг хангалтгүй гэж үзжээ.¹³ Ажлын үр дүн ингэж ялгаатай байгааг СЗХ-ноос үйл ажиллагаагаа явуулаад удаагүй байгаагаар холбон тайлбарласан байна. Үнэлгээний баримт бичигт Санхүүгийн мэдээллийн алба нь Монголбанкны бүтцэд шинээр үүсгэн байгуулагдсан бөгөөд МУҮАЭ чиглэлээр сургалтууд зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх болон Монголбанк, СЗХ болон Эрүүгийн цагдаагийн албаны нягт хамтын ажиллагааг сайшаан тэмдэглэсэн байна. МУҮАЭ арга хэмжээний хүрээнд хуулийн цоорхой болох компанийг бүртгэх явцад шууд бус эзэмшигчийн талаарх мэдээллийг шаардах эрх бололцоог СЗХ болон Улсын бүртгэлийн албанд олгох, хуулийг хэрэгжүүлэх хүн хүчний дутагдал, банкны сэжигтэй гүйлгээний тайланд тавигдах шаардлагыг сайжруулах хэрэгцээ байна. Түүнээс гадна, үнэлгээнд Монгол улсын хамгийн том албан бус салбар болох хувийн гуйвуулгын сувгууд нь мөнгө угаахад ашиглагдах өндөр магадлалтай болохыг дурьджээ.

¹² Мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр өгсөн бусад зөвлөмжүүдийг Хавсралт 1-ээс үзэж болно.

¹³ Энэхүү үнэлгээний тайланг АНДБ-ийн (<http://www.apgml.org>) вэб хуудаснаас үзэж болно..

Д. Нягтлан бодох бүртгэл болон аудитын стандартууд

33. Хэдийгээр Монгол улсын НББ-ийн Тухай Хуулинд нягтлан бодох бүртгэлийг Олон улсын стандартад нийцүүлж хөтлөнө гэж заасан боловч банкнаас бусад салбарт хэрэгжилт хангалтгүй байна. СЗХ-оос мэдээлж байгаагаар олон нягтлан бодогчид хуулийн заалтыг мөрддөггүй байна.¹⁴ Нөгөө талаар ОУНББС/ОУСТС-ын чухам аль хувилбарыг нь нягтлан бодогчид мөрдөх ёстой нь тодорхойгүй. Засгийн газраас ОУНББС-ыг орчуулсан боловч шинэчлэгдсэн зүйл, заалтуудыг (жишээ нь ОУСТС-д гэх мэт) албан ёсоор хараахан орчуулж гаргаагүй байна. Улсын нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллага болох Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь журам, заавар гаргадаг боловч өөрийн гишүүдийн дунд өргөн хүрээтэй, нэгдмэл стандарт боловсруулан хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай ажиллаж байна.

34. Аудитын стандарт нь мөн адил сул хөгжсөн боловч аудиторуудын ур чадвар нь өөр хоорондөө эрс тэс ялгаатай байна. Аудиторуудын хараат бус ажиллагаа нь нэн ялангуяа жижгэвтэр аудитын компаниудын хувьд асуудал үүсгэдэг бөгөөд тайлан мэдээ хадгалах ажил хангалтгүй хийгддэг. Монгол улсын Засгийн газраас Монголын нягтлан бодох бүртгэл болон аудитын стандартуудыг сайжруулах зорилгоор шат дараалсан арга хэмжээ авах үүднээс Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын чиглэлээр Стандарт, хэм хэмжээний Тайлангийн шинжилгээг гаргуулахаар Дэлхийн банкны шинжээчдийг урьж ажиллуулсан байна.

Е. Компаний зохистой удирдлага

35. Монгол улсын төрийн болон хувийн хэвшлийн аль алинд компанийн зохистой удирдлагын хөгжил олон улсын стандартаас ихээхэн хоцрогдолтой байгаа, цаашид хөрөнгийн зах зээл дээрх хөрөнгө оруулагчдын итгэл, тэдгээрийн оролцоог дэмжихийн тулд зохистой удирдлагыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүний нэг алхам нь СЗХ болон Худалдаа, аж үйлдвэрийн танхмээс хамтран Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагаас гаргасан зохистой удирдлагын зарчмуудад үндэслэсэн зохистой удирдлагын хэм хэмжээг батлахаар хамтран ажиллаж байна. Нөгөө талаас, удирдах дээд шатны байгууллагаас 1999 оны Компанийн тухай хуулийн компанийн ТУЗ-ийн орон тооны бус гишүүдийн тооны доод хязгаарыг зааж өгөх гэх мэт олон нарийн заалтуудыг нэмж оруулах, түүнээс гадна хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын доод хэмжээг тусгаж өгөх нь зүйтэй.

¹⁴ Банкууд нь хэд хэдэн тайлан мэдээг нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг бөгөөд Монголын стандартаас илүүтэйгээр Олон улсын стандартад нийцүүлсэн бүртгэл хөтлөхийг Монголбанкнаас шаардаж, үүнийг аудитын хяналт шалгалтын үед баримталдаг байна.

IV. САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ХӨГЖЛИЙН НЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

36. Санхүүгийн систем, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх томоохон төлөвлөгөөнүүд байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүднээс эдийн засгийн тогтвортой, бат бэх өсөлттэй байх нь чухал. Дээрх төлөвлөгөөнүүдийн хувьд нэн тэргүүний шийдвэрлэх тулгамдсан асуудлуудаар ялгаж, шат дараалан хүрэх арга замуудыг нарийвчлан авч үзэх хэрэгтэй. Засгийн газраас онцгойлон авч үзэж буй арга хэмжээнүүд нь (тухайлбал, орон сууцны болон жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх, хөгжлийн банк байгуулах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих), санхүүгийн сектор дахь шударга бус өрсөлдөөн эсвэл бусад гажуудлыг ялангуяа, зохисгүй үйл ажиллагаа гарах бололцоог үүсгэхээс зайлхийж зөв бүтцээр нь зохион байгуулах нь зүйтэй.

А. Орон сууцны санхүүжилт

37. Монголын орон сууцны зах зээл хурдацтай хөгжиж байна. Анх 2002 онд Азийн Хөгжлийн Банк (АХБ)- ны дамжуулан зээлдүүлэх орон сууцны зээлийг олгож эхэлжээ. 2007 оны 8 дугаар сарын байдлаар орон сууцны зээлийн багц банкны системийн нийт активын 4.5 хувь буюу ДНБ-ний 3.5 хувийг эзлэж байна. Орон сууцны зээлийн хүү өндөр, хугацаа нь богино байгаа нь зээлийн эрэлтийг өндөр орлоготой өрхөөр л хязгаарлахад хүргэж байна.¹⁵ Зээл нь хамгийн уртдаа 10 жилийн хугацаатай байж болох боловч бодит байдал дээр түүнээс богино хугацаатай байна. Зээл олгох үеийн зээл-бодит өртгийн харьцаа (LTV) нь 70-аас 80 хувь, зөвшөөрөгдсөн өр-орлогын харьцаа нь 30 хувьтай байна. Орон сууцны зээлийн эрсдэл маш бага, барьцаа хөрөнгийг хураах тохиолдол ховор гардаг нь орон сууцны зах зээл харьцангуй залуу, үл хөдлөх хөрөнгийн үнэ тогтмол өсч байгаатай холбон тайлбарлаж болно.

38. Зах зээлийн хөгжилд түлхэц үзүүлэх үүднээс орон сууцны зах зээлийн хөгжлийг төлөвлөн холбогдох зохицуулалтуудыг хууль, эрх зүйн актуудад тусган баталж, мөрдүүлэх шаардлагатай. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар орон сууцны зээл, түүний барьцаа хөрөнгийг банкнаас хураах чадамж нь үндсэн хуулиар олгосон иргэний амьдран суух анхдагч эрхтэй зөрчилдөж тодорхойгүй байдал үүсгэж байгаа нь орон сууцны зээлийн хүүг өндөр болоход нөлөөлж орон сууц худалдан авах чадамжийг бууруулж байна. Орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн тухай хуулийн төсөл батлагдсанаар орон сууцны зээлийн гэрээ, зээлдэгчийн зээлээ буцаан төлөх эсвэл саадгүйгээр орон сууцыг нь худалдахад илүү тодорхой зохицуулалт бий болно. Нөгөө талаас, орон сууцны зээлийг үнэт цаасжуулах, орон сууцны бондын тухай эрх зүйн актыг боловсруулж, нарийн тайлбарлах нь чухал. Мөн түүнчлэн, орон сууцны зээлийг үнэт цаасжуулахдаа эрсдэлийг үнэт цаас худалдан

¹⁵ Зээлийн хүү нь төгрөгийн хувьд 34 хувь, ам.долларын хувьд 18 хувьтай байна.

авагчаас холдуулах аливаа зорилгогүйгээр зөвхөн зах зээлийн үнэлгээнд бүрэн үндэслэх нь орон сууцны зах зээлийн хөгжилд ач холбогдолтой.

39. Засгийн газрын зүгээс Улсын хөрөнгийн бүртгэлийг сайжруулах болон орон сууцны зээл олгогч нь харилцагчдын мэдээллийн нууцлалыг хадгалах журам боловсруулах, санхүүгийн талаархи анхан шатны ойлголтыг нэмэгдүүлэх, үл хөдлөх хөрөнгийн стандарт, брокерийн үйлчилгээний чиглэлээр сургалтын хөтөлбөр баталж мөрдүүлэх тал дээр анхаарвал зохино. АХБ-аас хөрөнгийн бүртгэлийн системийг сайжруулахад шаардлагатай шинэчлэлүүдийг хийхэд туслалцаа үзүүлж байна. Үүнээс гадна, Мянганы Сорилын Корпорациас Улсын хөрөнгийн бүртгэлийн газарт автоматжуулах системийг шинэчлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Харилцагчдын мэдлэгийг дээшлүүлэх, зээлдэгчид зээлдүүлэгчээс санал болгож буй зээлийн эрсдэл, нөхцлөө нарийн тодорхойлох замаар орон сууцны зээлийн эрсдлийг бууруулж болно. Үл хөдлөх хөрөнгийн үнэлээчид тавигдах стандарт нь тэдгээрийн хараат бус ажиллагааг хангаад зогсохгүй үнэлгээнд ашиглах аргуудын наад захын шаардлагыг тодорхойлно. Үл хөдлөх хөрөнгийн брокерийн мэргэжлийн стандартуудыг тодорхойлж, үйлчилгээний хураамжийн талаарх мэдээллийг нийтэд түгээх нь зүйтэй.

Б. Хөрөнгийн зах зээлийн хөгжил

40. Дотоодын аж ахуйн нэгжийн дийлэнхи нь цар хүрээний хувьд жижиг хэвээр, гадаад санхүүжилтийн ихэнхи нь цөөн тооны томоохон гадаадын хөрөнгө оруулагчдаар хязгаарлаж байгаа зэрэг нь Монгол улсын хөрөнгийн зах зээл ойрын хугацаанд ямархуу цар хүрээнд хөгжиж чадах эсэх нь тодорхойгүй байна. Хөрөнгийн зах зээлийн хөгжил нь эрэлт-нийлүүлэлт хоёр талын аль алинг нь дэмжсэнээр бий болдог. Үүнд (i) Монголын хөрөнгийн зах зээлд шинэ тутам хөгжиж буй орнуудаас оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх байх; (ii) орон сууцны зээлээр болон бусад активаар барьцаалсан үнэт цаасыг гаргах; (iii) Монголд хадгаламжийн даатгалын төлбөрийг бий болгох; (iv) үнэт цаасны эрэлтийг нэмэгдүүлэх амьдралын даатгалын салбарыг хөгжүүлэх (v) хувийн хувьцааны санг (private equity funds) бий болгох (vi) хөрөнгийн зах зээл дээрх банкны зуучлалын болон хөрөнгө оруулагчийн үүргийг нэмэгдүүлэх боломжийг хангах үүднээс Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах; мөн (vii) гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн Монголын компаниудын тоог нэмэгдүүлэх зэргийг нэрлэж болно. Дээрх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх нь Монголын эдийн засгийн нэг ба түүнээс дээш хэд хэдэн салбарт үр ашигтай байж болох ч дотоодын хөрөнгийн зах зээлийг дэвшингүй хөгжилд хүргэх зорилгод эд бүгд үр дүнтэй байж чадахгүй бөгөөд дэлхийн хөрөнгийн зах зээл дээрх Монголын эзлэх байрыг тэр болгон нэмэгдүүлж чадахгүй.

41. 1990-ээд оны эхэн үеийн өмч хувьчлалын хөтөлбөрийн хүрээнд бүртгэгдсэн компаниудын тоо 2007 онд анх бүртгэгдсэнээс ялимгүй өссөн байна. Ихэнхи компанийн эзэмшигчид нь аудитлагдсан санхүүгийн тайланг тогтмол нийтэд мэдээлж

ажиллах тал дээр учир дутагдалтай байна. Хөрөнгийн зах зээлийг эрүүлжүүлэх, Монголын хөрөнгийн биржийн нэр хүндийг хамгаалах үүднээс 2007 оны 11 дүгээр сард бүртгэлд байсан нийт 380 компаниас 200-г бүртгэлээс хассан байна. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй. Үүнд: (i) хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчинг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчлэх; (ii) дунд болон урт хугацааны засгийн газрын буюу түүнтэй тэнцэхүйц өндөр чанартай бондын өгөөжийн муруйг тодорхойлох, хөгжүүлэхээр төлөвлөсөн орон сууцны зээлээр барьцаалсан үнэт цаасны зах зээл нь энэхүү өгөөжийн муруйг тодорхойлоход хамгийн тохиромжтой бенчмарк болно; (iii) арилжаа огцом тэлэх нөхцлийг хангах зорилгоор Үнэт цаасны клирингийн төв болон Төвлөрсөн Хадгаламжийн төвийн үйл ажиллагаа явуулах чадамжийг нэмэгдүүлэх зэргийг нэрлэж болно.

В. Хөгжлийн банк

42. Монголын эрх баригчдаас хөгжлийн банк байгуулах асуудлыг авч хэлэлцэж байгаа бөгөөд ингэхдээ эдийн засгийн сул хөгжилтэй салбарыг (дэд бүтцийн хөгжил гэх мэт) дэмжих тал дээр анхаарлаа хандуулах нь зүйтэй. Дэлхий нийтийн хэмжээнд хөгжлийн чиглэлээр амжилттай үйл ажиллагаа явуулж байгаад алдагдалд орсон банкуудын тоо хангалттай. Бусад орнуудын туршлагаас харахад засгийн газраас санхүүгийн шууд үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий санхүүгийн хувьд чадамжтай байгууллагуудыг үүсгэн байгуулах ажиллагааг дэмжих орчинг бий болгох нь ихээхэн ач холбогдолтой байдаг байна. Түүнээс гадна, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг зохих түвшинд нь хувийн хэвшлийнхэн авч явж чадаж байхад хөнгөлөлттэй хүүгийн нөхцлөөр харилцагчид үйлчлэх замаар хөгжлийн банкны үйл ажиллагаа нь санхүүгийн секторын төлөвшсөн хөгжлийг хойш татах нөхцлийг үүсгэхгүй байх нь чухал.

Г. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж

Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилт

43. Монголын ихэнхи банкууд бичил санхүү, жижиг-дунд үйлдвэрлэлд (ЖДҮ)-д санхүүжилт олгох үйлчилгээ үзүүлдэг бөгөөд санхүүжилтын хүртээмж хангалтгүй байдгаас ЖДҮ-ийн хөгжилд ихээхэн бэрхшээл учруулдаг байна. Шинээр батлагдсан ЖДҮ-ийн тухай хуулийн тодорхойлолтоор Монгол улсад бүртгэлтэй ихэнхи бизнесийн байгууллагууд нь ЖДҮ-ийн ангилалд багтахар байна. Гэсэн хэдий ч томоохон компаниудтай харьцуулахад ЖДҮ нь өөрийн өдөр тутмын үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгө болон , хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд байнга бэрхшээлтэй тулгардаг ажээ. Хүндрүүлж буй гол шалтгаануудаас дурьдвал зээлийн хүү харьцангуй өндөр, зах зээлийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал, зах зээлийн судалгаа, бизнес төлөвлөгөө боловсруулах чадавхи сул байдаг зэрэг байна.

44. Олон тооны банкууд ЖДҮ-ийн зээлдэгчдэд анхаарлаа хандуулж, тэдэнд хүрч ажиллах зорилт тавьдаг боловч эдгээр хөтөлбөрийн дийлэнх нь доноруудын

хандивын санхүүжилтэд суурилж байна. Эх үүсвэрийн зонхилох хувийг бүрдүүлдэг Бичил санхүүгийн хөгжлийн сан (БСХС) бичил бизнесийн санхүүжилтанд оролцдог гол том гурван банк болон хөдөө орон нутагт бичил санхүүжилтийн үйл ажиллагаа явуулах сонирхолтой бусад банкуудад хөрөнгийн эх үүсвэр олгож байна.¹⁶ Эдгээр байгууллагуудын зарим нь БСХС-ын болон бусад хандивлагчдын бага хүүтэй санхүүжилтэнд хэт найдаж байгаа нь ажиглагдсан. Урт хугацаанд эдгээр байгууллагууд байнгын хандивын хөтөлбөрт үндэслэн үйл ажиллагаа явуулах боломжгүй бөгөөд зах зээлийн хүүгийн түвшинд өөрсдийн үйл ажиллагааг явуулах чадвар эзэмшиж, өөрсдийн санхүүжилтийг олон төрлөөр баяжуулах замаар ЖДҮ-д зээл олгодог болох нь чухал. Мөн түүнчлэн, БСХС-ийн ирээдүйн бүтэц, зохион байгуулалтыг эргэн харах нь чухал бөгөөд ялангуяа Монголбанкин дээр байршиж байгаа нь Төв банкны хяналт шалгалтын үүрэгтэй аливаа сонирхлын зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах нь зүйтэй.

45. Батлагдаад удаагүй байгаа ЖДҮ-ийн тухай хуульд ЖДҮ-ийн Хөгжлийн санг санхүүгийн байгууллагуудад зах зээлийн түвшингээс доогуур хүүтэй зээл олгох үүрэг бүхий толгой төв болгон шинэчлэлт хийхээр санал боловсруулж оруулсныг эргэн харах шаардлагатай. Энэхүү шинэ хуулиар ЖДҮ-ийн санхүүжилтын хөгжилд тулгарч буй хэд хэдэн тулгамдсан асуудлыг хөндсөн байна. Гэвч, олон улсын туршлагаар ЖДҮ-ийн хөгжилд зах зээлийн механизмд суурилсан Засгийн газрын хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлснээр илүү өндөр үр дүнд хүрсэн нь харагдсан. ЖДҮ-д зах зээлийн түвшинээс доогуур хүүтэй зээл олгох сан бүрдүүлэх зэрэг захиргааны шууд аргууд нь ихэнхидээ ЖДҮ-ийн санхүүгийн сахилга батыг бууруулах, зээл олгогчдын зээлийн эрсдлийн үнэлгээ алдаатай хийгдэх нөхцлийг үүсгэдэг.

Технологийн шинэчлэл

46. Санхүүгийн байгууллагууд шинэ харилцагч татах, зах зээл дээрх байр сууриа хадгалан үлдээхийн тулд технологийн шинэчлэлүүдийг судлаж байна. Гэвч эдгээр шинэчлэлүүдийг дэмжих хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг цаашид хүчтэй бий болгох шаардлагатай. Банкууд банкны карт гаргах, электрон банкны үйлчилгээ санал болгох замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж байна. Хэдий тийм боловч банкуудын технологийн ашиглалт зарим тохиолдолд зохих хуулийн зохицуулалтгүйгээр хийгдэж байна. Тухайлбал, электрон гүйлгээний үнэн бодит байдал, гүйцэтгэл, электрон гарын үсгийн баталгаа, харилцагчийн хувийн мэдээллийн хамгаалалт болон банкны мэдээллийн нууцлал зэрэг нь хуульчлагдаагүй байна. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газраас дээрх асуудлыг хөндсөн хоёр хуулийн төсөл болон үүнтэй холбогдуулаад Иргэний хуульд оруулах нэмэлт

¹⁶ Дэлхийн банкны төслөөр Монголбанкны дэргэд байгуулагдсан БСХС нь одоогоор 18 санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж байгаагаас 10 нь банк, 8 нь ББСБ байна.

өөрчлөлтийг боловсруулаад байгаа бөгөөд 2008 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байна.

47. Картын үйлчилгээний бизнес хурдацтай хөгжих хандлагатай байгаа боловч электрон карт унших систем болон нэхэмжлэх системийн нэгдсэн сүлжээ байхгүйгээс удааширч байна. Зээлийн болон харилцахын картын гүйлгээний дийлэнхи хувь нь хоёр том банкаар дамжин хийгдэж эдгээр банкууд нь өөр бусад банкттай нийлээд өөр өөрийн карт унших системийг нэвтрүүлэхээр ажиллаж эхэлжээ. Эдгээр системүүдийн өөр хоорондоо зохицох боломжгүй ялгавартай байдал нь (зах зээл дэх байр сууриа хадгалах оролдлого байж болох) харилцагчид болон худалдааны байгууллагуудад ихээхэн бэрхшээлийг учруулж байна. Монголбанкны Картын болон Төлбөр тооцооны төвийг түшиглэн олон улсын картын техникийн стандартын дагуу Монгол улсын нэгдсэн карт боловсруулах системийг бий болгох бүрэн бололцоо байна. Картын тооцооны төвийн карт боловсруулах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө Монголбанкны зүгээс Төлбөр тооцооны төвийн карт унших арилжааны үйл ажиллагаа явуулах хуулийн эрх нээлттэй эсэхийг эргэн харах нь чухал.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛС: ЦОЧРОЛЫН СОРИЛ ЯВУУЛАХ АРГАЧЛАЛ БОЛОН СУУРЬ ТААМАГЛАЛУУД

48. Цочролын сорилыг ССҮХ-ийн баг Монголбанкттай нягт хамтран ажилласны үр дүнд тооцлоо. Сорилыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 16 банк нэг бүрээр болон нийт банкны системийг хамруулан 2007 оны 6 дугаар сарын эцсийн байдлаарх банкуудын дэлгэрэнгүй тайлан тэнцэлд үндэслэн хийлээ. Мөн түүнчлэн, ижил төстэй банкны гурван бүлэг тус бүрийн хувьд буюу I Бүлэг болох нийт зах зээл дээрх активын дөрөвний гурвыг эзлэх Монголын 5 том банк; II Бүлэг болох нийлбэр дүнгээр зах зээлийн 7.3 хувийг бүрдүүлдэг, хадгаламж татах цар хүрээ жижиг, өөрийн хөрөнгийн харьцаа өндөр (энэхүү бүлэгт багтах банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж харьцаа нь 40.4 хувь байна), хөрөнгө оруулалтын банкны чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 6 жижиг банк; болон III Бүлэг болох жижиг болон дунд хэмжээний үлдсэн 5 банкны хувьд сорилыг тус тус явууллаа. (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Монгол: Банкны үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд
(2007 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)

	1-р бүлэг	2-р бүлэг	3-р бүлэг	Нийт
Банкны тоо	5	6	5	16
Зах зээлд эзлэх хувь хэмжээ (Нийт активт эзлэх хувь)	72.4	7.3	20.3	100.0
Зах зээлд эзлэх хувь хэмжээ (Нийт хадгаламжид эзлэх хувь)	78.9	3.3	17.7	100.0
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (Эрсдлээр жигнэсэн активт эзлэх хувь)	12.3	40.4	13.1	15.2
Өөрийн хөрөнгө, активын харьцаа (Нийт активт эзлэх хувь)	9.2	40.8	10.9	11.9
Нийт активт эзлэх зээлийн хувь	61.7	81.4	68.6	64.5
Нийт хадгаламжид эзлэх зээлийн хувь	81.9	258.5	113.8	93.4
Зээлийн зориулалт салбараар (Нийт зээлд эзлэх хувиар)				
Хөдөө аж ахуй	9.7	1.7	4.1	7.9
Барилга	15.7	3.8	12.3	14.1
Уул уурхай	8.7	8.8	10.2	9.1
Үйлдвэрлэл	11.5	38.6	10.0	13.2
Худалдаа	29.2	31.4	27.2	28.9
Тээвэр, харилцаа	2.3	1.3	1.7	2.1
Бусад салбар	22.9	14.4	34.4	24.8
Зээлдэгчийн төрөл (Нийт активт эзлэх хувиар)				
Аж ахуйн нэгж	54.9	42.8	53.9	53.6
Өрх гэр	37.3	16.1	37.1	35.3
Нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээл	40.8	41.7	34.6	39.6
Нийт өрх гэрт олгосон зээлд эзлэх өрх гэрт гадаад валютаар олгосон зээл	11.2	22.5	16.5	12.9
Чанаргүй зээл / Нийт зээл	3.3	6.7	3.2	3.6
Болзошгүй эрсдлийн сан / Чанаргүй зээл	91.0	82.0	80.6	87.5
Чанаргүй зээлээр цэвэрлэсэн болзошгүй эрсдэлийн сан / Өөрийн хөрөнгө	2.0	2.4	3.8	2.4
Активын өгөөж	3.0	1.2	0.7	2.4
Өөрийн хөрөнгийн өгөөж	46.4	2.5	6.2	22.1
Түргэн борлогдох актив / Нийт актив	33.7	15.3	22.1	30.0
Түргэн борлогдох актив / Богино хугацаат пассив	35.7	25.9	23.4	32.7

Эх сурвалж: Монголбанк, ажилтны тооцоолол

Аргачлал

49. Цочролын сорил нь мэдрэмтгий байдал буюу хүчин зүйлийн өөрчлөлтийн шинжилгээ, орчны өөрчлөлтийн шинжилгээний аль алийг нь багтаасан. Мэдрэмтгий байдлын цочролын сорилоор зээлийн хүү, ханш болон зээлийн эрсдлийг тус тусад нь бий болгож банкны салбарт гарч болох өөрчлөлтүүдийг судалж үзсэн бол орчны хүчин зүйлийн өөрчлөлтийн нөлөөллийг шинжлэхдээ макро эдийн засгийн гурван өөр төрлийн шок буюу гэнэтийн өөрчлөлтийн орчинд банкуудад үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийжээ. Эдгээр сорилуудын зорилго нь онцгой хэдий ч байж болох үйл явдлын улмаас бий болох эрсдлийн хүчин зүйлд тодорхой өөрчлөлт оруулснаас хамааран банкуудын санхүүгийн байдалд ямар нөлөөлөл үзүүлж болох талаар судалгаа хийх явдал байлаа.

50. Бүх төрлийн сорилоор тодорхой шокийн улмаас үүсч болох цэвэр ашиг, алдагдлын өнөөгийн үнэ цэнийг тооцоолж, түүгээр өөрийн хөрөнгөд нэг удаагийн тохируулга хийсэн байна. Зээлийн чанаргүйтэх эрсдлийг тооцохдоо зээлийн эрсдлийн санг нэмэгдүүлж, тэрхүү дүнгээр зохистой харьцаанд тооцогдох өөрийн хөрөнгийн дүнг бууруулсан, харин гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд ашиг алдагдлын хувиар өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дахин үнэлж хүүгийн

эрсдлийг хүүтэй актив, пассивын хувьд хугацаа, дахин-үнэлгээнээс хамааруулан цэвэр ашиг, алдагдлын дүнг хямдруулж өөрийн хөрөнгөд эзлэх хувиар тооцоолон гаргажээ.

Дэвшүүлсэн таамаглалууд

51. Цочролын сорилд ашиглагдсан шокийн цар хүрээ, хэмжээг тодорхойлохдоо голлох хүчин зүйлсийн түүхэн болон боломжит өөрчлөлтүүдэд үндэслэсэн болно. Хүү, ханш, зээлийн эрсдлийн банкинд үзүүлэх нөлөөллийг хүчин зүйл нэг бүрийн нөлөөллөөр тооцоолсон байна:

- **Гадаад валютын ханшийн эрсдэл.** Төгрөгийн ханш өөрчлөгдснөөр Монголын банкуудад ямар нөлөө үзүүлж болохыг хоёр сорилыг ашиглан үнэлсэн: (1) төгрөгийн ханш нь бүх гадаад валютуудтай харьцуулахад нэгэн зэрэг 15 хувиар буурах болон (2) төгрөгийн ханш нь бүх гадаад валютуудын эсрэг нэгэн зэрэг 20 хувиар өсөх. Төгрөгийн ханш буурах хувийг тооцоолохдоо 1999 оны 1 дүгээр сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд гарсан төгрөг ам.доллартай харьцуулахад нэг улиралд хамгийн ихээр унасан (1999 оны 3 дугаар сарын байдлаар 15.4 хувиар төгрөгийн ханш унажээ) хэмжээтэй дүйцүүлж авсан бол валютуудын эсрэг чангарах үнэлгээг цэвэр таамаглал хэлбэрээр авсан. Мөн түүнчлэн, Хятадын юаны ханшийг бусад валютуудтай харьцуулахад 10 хувиар чангарна гэсэн таамаглал дэвшүүлж, банкуудын тайлан тэнцэлд гарах өөрчлөлтийг давхар тооцоолсон нь өнөөгийн нөхцөл байдалд үүсч болзошгүй бодит таамаглал болсон.
- **Хүүгийн эрсдэл.** Дараах сорилуудыг авч үзсэн байна: (1) бүх хүүгийн түвшин жигд 10 хувиар өснө; (2) төгрөгийн өгөөжийн муруй босоо болох (урт хугацааны хүүгийн түвшин 5 хувиар өсөж, богино хугацааны хүүгийн түвшин 2 хувиар буурах); болон (3) төгрөгийн өгөөжийн муруй хэвтээ болох (богино хугацааны хүүгийн түвшин 5 хувиар өсч, урт хугацааны хүүгийн түвшин 2 хувиар буурах). Бүх хүүгийн түвшинг жигд 10 хувиар өснө гэж үзэхдээ 1999 оны 1 дүгээр сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд төв банкны үнэт цаасны хүүнд улиралд гарсан хамгийн өндөр өсөлтийг (2003 оны 6 дугаар сарын байдлаар 11.4 хувь) үндэслэн тогтоожээ. Харин өгөөжийн муруйн босоо/хэвтээ болох нөхцлийг цэвэр таамаглалын үндсэн дээр тодорхойлсон.
- **Зээлийн эрсдэл.** Зээлийн эрсдлийг гурван өөр төрлийн сорилоор үнэлсэн байна: (1) цаг агаарын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаанд гарах гэнэтийн өөрчлөлт; (2) чанаргүй зээлийн өсөлт өргөн хүрээнд гарах; болон (3) зээлүүдийг нэг шатлал бууруулж ангилах.
 - Эхний сорил нь цаг агаарын гэнэтийн өөрчлөлт гарна гэсэн таамаглал дэвшүүлж эрсдлийн үнэлгээг хийжээ. Монгол улсад цаг уурын гэнэтийн сөрөг өөрчлөлт тодорхой давтамжтайгаар гардаг тул ийм шок үүсэх

магадлал өндөр юм. Өвлийн дундаж улирал нь харьцангуй урт, цаг агаарын хувьд хүндхэн болж өнгөрдөг бол зарим жилүүдэд ихээхэн бэрхшээл учруулдаг байна. 1999, 2000 онуудад зундаа томоохон ган болсны дараагаар 2000, 2001 онуудад өвөл хэт хүйтэрснээс Монгол улсын ДНБ-ний тавны нэгийг бий болгож хөдөө аж ахуйн голлох салбар болох мал аж ахуйд ихээхэн хохирол (нийт малын тоо толгойн дөрөвний нэг нь сүйрсэн) учруулж байжээ. Сорилд банкуудын хөдөө аж ахуйн салбарт зээл олгосон зээлийн тал хувийг чанаргүй болж эргэн төлөгдөх боломжийг тэг гэж үзсэн.

- Хоёр дахь сорилоор нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувийг 10 хувиар өсөхөөр таамаглал дэвшүүлсэн. Энэхүү хувийг тодорхойлохдоо 1997 оны 4 дүгээр сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд системийн хэмжээнд чанаргүй зээлийн хувь хэмжээнд нэг улиралд гарсан хамгийн өндөр (1997 оны 12 дугаар сарын байдлаарх 9.9 хувийн үзүүлэлт) хувьтай жишиж гаргажээ. Хэвийн бус, эргэлзээтэй, муу ангилалд ангилагдсан зээлийн эрсдлийн сан байгуулах дундаж хувиар зээлийн эрсдэлийн алдагдлын хэмжээг (ЗЭАХ) тооцсон байна (ойролцоогоор 72 хувь).
- Гурав дахь сорилоор хэвийн зээлийн багцын 10 хувиар хугацаа хэтэрч, бусад ангилалын зээлүүд нэг шатлалаар буурч (хугацаа хэтэрсэн ангилал дахь бүх зээлийн багцыг хэвийн бусд, хэвийн бус ангилал дахь бүх зээлийн багцыг эргэлзээтэйд болон эргэлзээтэй ангилал дахь бүх зээлийн багцыг муу буюу алдагдал ангилалд гэх мэт) холбогдох эрсдлийн санг нэмэгдүүлэн тооцсон байна.

52. Мэдрэмтгий байдлын шинжилгээнээс гадна макро эдийн засгийн өөр хоёр орчинг авч үзсэн. Нэг дэх хувилбарт худалдааны нөхцөлд гэнэтийн өөрчлөлт гарна гэж үзсэн бол хоёр дахь хувилбарт “Голланд өвчин” хэлбэрийн шок болж худалдаа болон гадаадаас чиглэх хөрөнгийн орох урсгалд огцом үсрэлт гарна гэж үзжээ.

- *Орчин 1: гадаад салбарын гэнэтийн сөрөг өөрчлөлт буюу шок.* Эхний орчинд худалдааны нөхцөлд гэнэтийн өөрчлөлт гарна гэсэн таамаглал дэвшүүлсэн бөгөөд үүгээр дэлхийн зах зээл дээрх зэсийн (Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн) үнэ буурахын хамт газрын тос болон бусад шатах, тослох материалын (Монгол улс нефть цэвэр импортлогч улс) үнэ тогтвортой байна гэж үзлээ. Зэс үйлдвэрлэгч компаниуд Монголын эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээр нь Монгол улсын ДНБ-ний тавны нэг, экспортын бүтээгдэхүүний талаас илүү хувь, төсвийн орлогын дөрөвний нэгийг бүрдүүлдэг. Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ буурах магадлал өндөр байгаа юм. Урт хугацаанд харьцангуй тогтвортой байсны эцэст дэлхийн зах зээл дээр зэсийн эрэлтийн дийлэнхи хувийг тодорхойлдог Хятадын хурдацтай өсөлтийн нөлөөгөөр зэсийн үнэ 2003 оноос хойш огцом өссөн. Гэсэн хэдий ч ирээдүйд хийгдэхээр төлөвлөсөн гэрээгээр зэсийн үнэ дараагийн

цөөн хэдэн жилд одоогийн өндөр түвшнээс буурах хандлагатай байгаа бол газрын тосны үнэ одоогийн түвшиндээ хэвээр байх хүлээлттэй байна. Зэсийн үнэ ихээхэн буурснаар уул уурхайн салбарт олгосон зээлийн чанар огцом муудаж (уул уурхайн салбарт олгосон нийт зээлийн 50 хувь нь муу ангилалд шилжих), энэ нь төгрөгийн ханш 10 хувиар сулрах, хүү өсөх, улмаар нийт эдийн засгийн үйл ажиллагаа удаашрах нөхцлийг бүрдүүлнэ гэж таамаглажээ.

- **Орчин 2: гадаадаас орж ирэх хөрөнгийн урсгал огцом нэмэгдэх.** Энэхүү орчинд худалдаа болон хөрөнгийн гаднаас орох урсгал огцом нэмэгдснээр төгрөгийн ханш 20 хувиар чангарах, энэ нь инфляцийн хүчтэй дарамтыг бий болгох, улмаар бүх худалдааны болон худалдааны бус салбарын үйл ажиллагааны үр дүн бага зэрэг муудах байдлыг бий болгоно. Энэ тохиолдолд, хүүгийн түвшин нь одоогийн түвшинд хэвээр хадгалагдана гэж үзсэн байна.

Хүснэгт 4. Монгол: Мэдрэмтгийн байдлын шинжилгээний товч үр дүн ⁽¹⁾
(2007 оны 6 дугаар сарын 30-ны үзүүлэлтүүдэд үндэслэсэн)

Сорил	Өөрийн хөрөнгө (Эрсдлээр жигнэсэн активт эзлэх хувь)			
	1-р бүлэг	2-р бүлэг	3-р бүлэг	Нийт
Суурь Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	12.3	40.4	13.1	15.2
А. Мэдрэмтгийн байдлын шинжилгээ				
<i>Ханшийн эрсдэл</i>				
Ханш 15 хувиар буурах	13.0	42.1	13.1	15.8
Ханш 20 хувиар өсөх	11.4	38.2	13.0	14.3
Хятад юаны ханш 10 хувиар өсөх	12.3	40.4	13.0	15.2
<i>Хүүгийн эрсдэл</i>				
Хүүгийн түвшин 10 нэгж хувиар өсөх	10.1	38.2	11.1	13.0
Өгөөжийн муруй хумигдах	11.6	39.7	12.5	14.5
Өгөөжийн муруй тэлэх	12.3	40.5	13.0	15.2
<i>Зээлийн эрсдэл</i>				
Хөдөө аж ахуйн салбарт үүсэх шок	8.6	40.0	11.6	12.3
Чанаргүй зээлийн хувь 10 нэгж хувиар өсөх	6.7	36.8	7.7	9.8
Зээлийн ангиллыг нэг түвшингээр бууруулах	11.1	38.4	11.8	13.8
В. Орчны шинжилгээ				
Орчин 1	7.1	37.8	7.0	10.1
Орчин 2	9.5	36.9	11.2	12.5

(1) I Бүлэг болох нийт зах зээл дээрх активын дөрөвний гурвыг эзлэх Монголын 5 том банк; II Бүлэг болох нийлбэр дүнгээр зах зээлийн 7.3 хувийг бүрдүүлэх, хадгаламж татах цар хүрээ жижиг, хөрөнгө оруулалтын банкны чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 6 жижиг банк; болон III Бүлэг болох үлдсэн жижиг болон дунд хэмжээний 5 банк байна

ХАВСРАЛТ 2. МОНГОЛ УЛС: ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

53. Гишүүдийн хөрөнгийг хамгаалан санхүүгийн хариуцлагыг хангуулах албан ёсны тодорхой зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоо бүрдээгүй байхад ХЗХ-ны салбарын үйл ажиллагаа хурдацтай хөгжсөн. СЗХ 2006 оны эхээр үүсгэн байгуулагдахаас өмнөх хугацаанд ХЗХ-д Засгийн газрын аливаа нэгжийн хяналт зохицуулалтанд харьяалагдаагүй, хадгаламж зээлийн болон холбогдох гишүүддээ банкны бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэх хоршоод хоорондын зуучлалын үүргийг зохистой түвшинд ялган зохицуулаагүй Хоршоодын тухайн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байлаа. Үүний үр дүнд санхүүгийн чадавхийн хувьд сул ХЗХ-д ихээр үүсгэн байгуулагджээ. ХЗХ-дод хяналт хэрэгжүүлж эхэлснээр 2006 оны байдлаарх тус салбарын нийт активын талаас илүү хувийг эзлэх 32 ХЗХ-ын үйл ажиллагаа доголдож дампуурчээ.¹⁷ Үүний уршгаар ХЗХ-дын салбарын нэр хүнд унаж өнөөг хүртэл сэргээгүй байна. ХЗХ-ний үйл ажиллагааг тусгайлан зохицуулах хуулийн төсөл 2006 онд боловсруулагдсан боловч өнөөг хүртэл батлагдаагүй байна. СЗХ нь 2006 оноос хойш ХЗХ-дын үйл ажиллагааг хянах туршлага хуримтлуулаад байгаа бөгөөд хуулийн төслийн холбогдох хэсэгт энэхүү шалгалтын хэрэгжилтийг зохистой түвшинд хангах зорилгоор өөрчлөлт оруулах шаардлага тулгарч болзошгүй. Мөн хуулийн төсөл батлагдахаас өмнө ХЗХ-дын салбарт үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдээс холбогдох саналыг авч харгалзан үзэх нь зүйтэй.

54. ХЗХ-дын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн зохистой тогтолцоо бүрдээгүй, гишүүдээс эдгээрийн талаар ирүүлж буй санал гомдлын хэмжээ их байгаа зэргийг үндэслэн СЗХ-ноос ХЗХ-дын үйл ажиллагааны зөвшөөрөл олгох түр журмыг 2006 онд батлажээ. 2006 оны байдлаар бүртгэлтэй байсан 955 ХЗХ-дын 500 орчим нь 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө (зөвшөөрөл авах өргөдлийн хүлээн авах сүүлчийн хугацаа) үйл ажиллагааны зөвшөөрөл авахаар хүсэлтээ ирүүлсэн байсан бөгөөд олон хоршоо холбогдох зөвшөөрлийг авчээ. Эдгээр шинээр зөвшөөрөл авсан ХЗХ-дын дийлэнх хувь нь үйл ажиллагаагаа нийслэл хотод явуулж хадгаламжийн өндөр хүү амлан банкны салбартай шууд өрсөлдөж байна.

55. СЗХ-ноос ХЗХ-дод хяналт шалгалт хийх хүчин чадлын хүрээнд чадвартай бөгөөд туршлагатай ажилтнаар хязгаарлагдмал байдгаас гадна шалгалт хийх хянан шалгагчдын тоо хүрэлцдэггүй байна. 2006 оны 6 дугаар сараас хойш СЗХ-с тухайн хоршоодын хэмжээг үл харгалзан 50 ХЗХ-дын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг явуулсан. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан ХЗХ-дын тоо 200 гарч

¹⁷ Дампуурсан ХЗХ-дын үйл ажиллагаанаас учирсан нийт алдагдлын талыг (33.0 тэрбум төгрөг) төрийн төсвөөс барагдуулахаар болсон байна. 2008 оны 4 дүгээр сарын байдлаар 19.0 тэрбум төгрөгийн гомдлыг барагдуулаад байлаа.

болзошгүй байдлыг харгалзан үзэж СЗХ-ноос шинээр зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын үндсэн үзүүлэлтийн мэдээллийг цуглуулж тэдгээрийг том, дунд, жижигт (энэ нь активын хэмжээ, гишүүдийн тоо болон бусад үзүүлэлтээр) ангилан, газар дээрх шалгалтыг хэрэгжүүлэх шатласан загварын тогтолцоог ашиглах талаар судлах шаардлагатай. СЗХ-ны хүний нөөцийн хүчин чадлыг харгалзан үзсэнээр, түүнээс бүх л ХЗХ-дын үйл ажиллагаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шаардлага тавьж зохицуулах нь шаардлага байхгүй, мөн боломжгүй ч байх талтай. Хуулийн төсөл хэлэлцүүлэгдэх хугацаанд энэхүү шаталсан хяналт шалгалтын загварын бусад улсуудын тогтолцоог судалж, хуульд тусгагдсан хяналт шалгалтын холбогдох зүйлүүдэд хамаарах нэмэлт өөрчлөлтийг хийх нь тохиромжтой байх талтай.

**НЭМЭЛТ ХАВСРАЛТ I. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЗАРИМ СТАНДАРТ, ХЭМ
ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Энэхүү хавсралт нь Үр Ашигтай Банкны Хяналт Шалгалтад зориулсан Базелийн Үндсэн Зарчмууд (ҮАБХШБҮЗ)-ыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон Мөнгөний болон Санхүүгийн Бодлогын (МСБ) Ил Тод Байдлын талаарх Зохистой Үйл ажиллагааны Хэм Хэмжээг мөрдүүлж ажиллаж буй эсэхэд хийсэн үнэлгээний дүгнэлтийг нэгтгэн харуулсан.

ҮАБХШБҮЗ-ын мөрдөлтийн үнэлгээний нарийвчилсан дүгнэлтийг Стефан Спамер (Германы Төв банкны банкны хяналт шалгалтын шинжээч), Уолтер Зуник (АНУ-ын Холбооны нөөцийн сан буюу Төв банкны банкны хяналт шалгалтын шинжээч асан) нар хийсэн.

Мөнгөний бодлогын ил тод байдлын үнэлгээг гардан гүйцэтгэгч нь Елена Лоукьянова (ОУВС-ийн Мөнгө болон хөрөнгийн захын газар) байсан бөгөөд Сунг Хо Ли (ОУВС-ийн Ази номхон далайн газар)-ийн тусласан болно.

Дээрх үнэлгээнүүдэд мэдээллийн олон эх сурвалж ашигласнаас:

- Монгол улсын эрх барих дээд шатны байгууллагуудаас бие даан хийсэн үнэлгээнүүд;
- Холбогдох хууль, эрх зүйн актууд, тогтоол, шийдвэр, журам, заавар, бодлогын бичиг баримтууд болон бусад;
- Эрх бүхий байгууллагуудтай нэг бүрчлэн хийсэн ярилцлагууд;
- Холбогдох бусад дээд шатны байгууллагууд болон хараат бус үйл ажиллагаа явуулдаг хөндлөнгийн этгээдүүдтэй хийсэн уулзалт болон
- Банк болон бусад санхүүгийн салбарын байгууллага, холбоодуудтай хийсэн уулзалтууд зэрэг болно.

**Үр ашигтай банкны хяналт шалгалтад зориулсан Базелийн үндсэн
зарчмуудыг мөрдөж буй байдал**

Үнэлгээнд ашигласан мэдээлэл, аргачлал

56. Үнэлгээг банкны хяналт шалгалтын талаарх хууль, эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн байдалд чиглүүлж, үндсэндээ Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас гаргасан бусад журам, зааврууд, ажлын хэсэг ирж ажиллахаас өмнө Монголбанкинд урьдчилан явуулсан санал асуулгын хариу болон Монголбанкнаас урьдчилан хийгдсэн өөрийн үнэлгээ зэрэгт суурилж явууллаа. Үнэлгээ хийсэн ажлын

хэсгийн зүгээс үнэлгээ хийх явцад харамгүй туслалцаа үзүүлсэн хүмүүст маш их талархаж байна.

57. Үнэлгээг чанарын үзүүлэлтүүдэд суурилан гаргасан бөгөөд 2006 оны 10 дугаар сард шинэчлэгдсэн Үндсэн Зарчмуудын баримт бичигт үндэслэн хийлээ. Үнэлгээг Үндсэн Зарчмуудын Аргачлалын ерөнхий шалгуур үзүүлэлт нэг бүрээр шинжилж, шаардлагатай тохиолдлуудад нэмэлт шалгуураар дүгнэв.

Байгууллагын болон Макро эдийн засгийн орчин, зах зээлийн тогтолцооны талаарх тойм

58. Банкуудын үйл ажиллагаа явуулж буй макро эдийн засгийн орчин нь сул хөгжсөн гэж хэлж болох боловч хэд хэдэн хүнд өвлийн уршгаар хөдөө аж ахуйн салбарт учирсан хохирол нөхөгдөж, экспортын бүтээгдэхүүний үнэ өмнөхөөс хамгийн өндөр түвшиндээ хүрснээр эдийн засаг хурдацтай хөгжиж байна. Эдийн засгийн өсөлт нэмэгдсэн нь өрхийн орлого нэлээдгүй нэмэгдэх, ялангуяа төрийн албан хаагчдын хувьд энэ нь илүүтэйгээр ажиглагдаж, банкны зээлийн хэмжээ ихээхэн өссөн байна. ҮАБХШБҮЗ-уудын үнэлгээг хийх явцад банкны зээл, хадгаламжийн хүү нэрлэсэн болон бодит дүнгээр өндөр хэвээр байсан боловч шилжилтийн ижил түвшинд байгаа бусад орнуудын түвшин үрүү аажмаар ойртож байна.¹⁸ Банкны хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү нь хэдийнэ эдгээр орнуудын түвшинд очсон байгаа нь банкны салбарт тодорхой өрсөлдөөн байгааг илэрхийлнэ.

59. Монгол улсын банкны системд 16 арилжааны банк бүртгэгдэн банкны үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээр нь санхүүгийн системийн нийт активын 95 гаруй хувийг бүрдүүлдэг. Банкны системийн нийт актив 2003 онд ДНБ-тэй харьцуулахад 52 хувьтай байсан бол 2007 оны байдлаар энэ нь 87 орчим хувь буюу нэрлэсэн дүнгээр 4.3 дахин өссөн байна. Түүнээс гадна хадгаламж татах эрх бүхий олон тооны ХЗХ-д үйл ажиллагаа явуулдаг. Ерөнхийдөө цар хүрээний хувьд хязгаарлагдмал ч томоохонд тооцогдох хэд хэдэн ХЗХ-ууд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Монголбанк нь Монгол улсад банкны байгууллагын хяналт шалгалт, лиценз олгох асуудлыг дангаар шийдвэрлэдэг эрх бүхий байгууллага юм. Харин ХЗХ-ууд, банк бус санхүүгийн байгууллагууд болон хөрөнгийн зах зээлд Санхүүгийн Зохицуулах Хороо хяналт тавьж ажилладаг байна.

¹⁸ 2007 оны эцэс болон 2008 оны эхээр гарсан инфляцийн нөлөөгөөр нэрлэсэн хүүгийн бууралт удаашрах магадлалтай байна.

Үр ашигтай банкны хяналт шалгалтын угтвар нөхцөлүүд

60. Банкны салбарыг хянах эрх баригчдын хяналтаас гадуур тодорхой угтвар нөхцлүүд бүрдээгүй байхад банкны хяналт шалгалтын үр ашигтай систем бүрдүүлж, ажиллах нь хэцүү байдаг. Гол угтвар нөхцөлд:

- **Макро эдийн засгийн бодлогын оновчтой, тогтвортой байдал.** Монгол улсын эдийн засгийн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд маш өндөр түвшинд байв. 2002 оноос хойшхи ДНБ-ний жилийн дундаж өсөлт 7 гаруй хувь, 2007 оны дунд үе гэхэд инфляци нэг-оронтой тоонд болж буурч, 2006-2007 онуудад төсөв, төлбөрийн тэнцлийн урсгал дансны тэнцэл ашигтай гарсан. Гэвч, хурдацтай цэцэглэж буй эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогыг тэлэх чиглэл барьсны нөлөөгөөр 2007 оны эцсээр инфляци өсч эхэлсэн.
- **Хууль, эрх зүйн орчин.** Банкны хяналт шалгалтын чиглэлээр хууль, эрх зүйн зохистой тогтолцоо бүрдэж, түүнийг сайжруулах тал дээр нэлээд ахиц гарч байгаа боловч дутагдалтай зүйлс байсаар байна. Хэд хэдэн өөрчлөн найруулах, шинэчлэх шаардлагатай хуулиуд байгаагаас: (1) банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга; (2) үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга; (3) ипотекийн зээлийн барьцааны тухай хууль; (4) ипотекийг барьцаалж үнэт цаас гаргах тухай хууль зэргийг батлах шаардлага байна. Түүнээс гадна, зарим хуулийн процедурыг сайжруулах шаардлагатай байна, тухайлбал, Дампуурлын тухай хууль 1996 онд батлагдсан боловч батлагдсанаас хойш цөөн тооны тохиолдол гарч ажиллагаа удаан, чирэгдэл ихтэй байдаг байна.
- **Зах зээлийн үр ашигтай сахилгын тогтолцоо.** Банкуудаас олон улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудыг дагаж мөрдөх, нэлээд олон тайлан мэдээ гаргаж ирүүлэхийг шаарддаг байна. Бүртгэлийн ажиллагааг үнэн зөв явуулж буй эсэхийг шалгах нь банкны газар дээрх шалгалтын ажлын нэг хэсэг юм. Банкны тухай хуульд заасны дагуу банкууд нь санхүүгийн тайланг сар бүр, аудитаар баталгаажсан өмнөх жилийн санхүүгийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг. Мөн түүнчлэн, энэхүү хуулиар банкнаас нийтэд мэдээлж буй санхүүгийн жилийн тайлан нь зохих хөндлөнгийн байгууллагаар баталгаажиж, хөндлөнгийн аудиторын дүгнэлт хийгдсэн эсэх болон санхүүгийн тайлан, бүртгэлийн системийн найдвартай байдлыг хангах үүрэг хариуцлагыг банкны удирдлага, ТУЗ-д үүрүүлэх бүрэн эрхийг Монголбанкинд олгодог байна.
- **Зохих ёсны системчилсэн нийтийн аюулгүй сүлжээг хангах нөхцлийг бүрдүүлэх механизм.** Хадгаламжийг заавал даатгах даатгалын системийн талаар хэлэлцэж буй боловч түүний зайлшгүй бүрдүүлсэн тогтолцоо одоогоор байхгүй. 1990-ээд оны эцэст банкны секторт гарсан хэд хэдэн хүндрэлүүдийн улмаас банкны хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны

зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэн холбогдох арга хэмжээг дээд шатны эрх бүхий байгууллага авах үүднээс хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүсчээ. Энэхүү шинэчлэлийн үр дүнд банкны секторыг хувьчлах ажил хийгджээ.

Үнэлгээний үндсэн дүгнэлтүүд

61. Үнэлгээний үр дүнд хийсэн гол дүгнэлтүүдийг нэгтгэн дараах байдлаар харуулав:

- **Зорилго, хараат бус байдал, эрх мэдэл, ил тод байдал болон хамтын ажиллагаа (ҮЗ 1).** Монголбанкны хяналт шалгалтын зорилго, хуулийн ёсны эрх мэдэл нь баталгаажсан бөгөөд түүний шийдвэр гаргах, хөрөнгийн эх үүсвэрийн хувьд албан ёсоор бие даасан байдал нь зохих шаардлагыг хангаж байна. Гэсэн хэдий ч, ажил үүргийн хангалтгүй гүйцэтгэл болон ашиг сонирхлын зөрчлийн улмаас Монголбанкны ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаануудыг маш ерөнхий байдлаар тодорхойлсон бөгөөд өнгөрсөн хугацаанд Засгийн газар өөрчлөгдсөний дараа Монголбанкны ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлж байсан тохиолдлууд хэд хэд гарч байжээ. Түүнээс гадна, өөрийн ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэж хэрэгжүүлсэн арга хэмжээнийх нь төлөө Монголбанкны эсрэг гаргасан шүүхийн нэхэмжлэхийн эсрэг түүнийг хамгаалсан албан ёсны хууль эрхзүйн зохицуулалт байхгүй байна.
- **Банкны үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгох болон банкны бүтэц, зохион байгуулалт (ҮЗ 2–5).** Банкны үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актууд нь өргөн хүрээг хамарсан боловч зарим дутагдалтай зүйлс байна. Нэн ялангуяа, банкны удирдах дээд албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах мэргэжил боловсрол, ажлын туршлагатай холбоотой шалгуур заалтуудыг нарийвчлан тусгах нь зүйтэй. Мөн түүнчлэн, тусгай зөвшөөрлийг олгоход худал мэдээлэл ирүүлсэн нь нотлогдвол бүртгэснээс хойш зөвхөн нэг жилийн хугацаанд зөвшөөрлийг хураах тухай заасан байна. Үүнээс гадна, Банкны тухай хуулиар дээр зааснаас бусад тохиолдолд банкинд томоохон хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч шинээр ороход аливаа зөвшөөрөл авах, мэдэгдэл явуулах шаардлага тавиагүй, банкууд нь өөрийн охин, хараат компаниудын тайланг нэгтгэн нэгдсэн тайлан гаргах шаардлагагүй бөгөөд банкны банкны-бус үйл ажиллагаа явуулдаг охин компани/холбоотой этгээдүүдийн эрсдлийг бууруулах асуудлыг хөндсөн аливаа хууль, эрх зүйн акт, заавар байдаггүй байна.
- **Зохистой харьцааны шаардлага, журам заавар (ҮЗ 6–18).** Банкны дээд удирдлага нь зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны, хуулийн болон нэр хүндийн эрсдэл гэх мэт эрсдлийн төрөл нэг бүрээр зөвшөөрөгдсөн хязгаарыг тогтоох үүрэг хүлээдэг. 2006 онд энэхүү шаардлагыг өндөржүүлж шийдвэр

гаргах дээд шатны байгууллагын тавьсан шаардлагыг биелүүлэхэд удирдлагын зүгээс тухайн банкны үүрч буй эрсдлийн талаар наад захын ойлголттой байх, дотоод хяналтын чадварлаг тогтолцоог бүрдүүлэхэд үндсэн суурь болох ёстой ажээ. Зах зээлийн эрсдлийн тооцоо, өөрийн хөрөнгийн тохируулга болон тайланд тавигдах шаардлагууд Монгол улсад бүрэлдсэн байгаа бөгөөд Монголбанкны зүгээс математик загварчлал болон эрсдлийн үнэлгээний үр ашигтай байдалд хяналт тавьдаг байна. Монголбанкнаас хүүгийн эрсдлийг хянах, удирдах асуудлыг зохицуулсан холбогдох бодлого, заавар журмыг баталж гаргасан боловч БҮЗ-уудыг үнэлэх хугацаанд хөрвөх чадварын эрсдлийн журмыг хараахан боловсруулж гаргаагүй байв. Нөгөө талаар, зарим жижиг банкууд нь олон төрлийн эрсдлийг тооцон хянах түвшинд хүрээгүй байна. Эрсдлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлт нь “дан ганц” банкны өөрийн хөрөнгөөр тодорхойлогдож байгаа ч зарим тохиолдолд сайн дураар өөрийн хөрөнгийн нэгдсэн үнэлгээг хийдэг бөгөөд нэгдсэн хяналт шалгалт хийх тухай журмын төслийг боловсруулах шатанд ажиллаж байна. Нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцыг хянахад “холбогдох этгээд”-ийн талаарх тодорхойлолт, ойлголтыг нарийн заагласан хуулийн зүйл, заалт байхгүй байгаа нь бэрхшээл учруулдаг байна. Үүнийг богино хугацаанд засварлах боломжтой боловч нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцыг тодорхойлох босго, түүний талаарх ойлголтыг тодорхойлж өгөх нь зүйтэй.

- **Хийгдэж буй хяналт шалгалтад ашиглаж буй аргууд, (ҮЗ 19–21).** Газар дээрх болон зайнаас тавих шалгалтын холбогдох журам, зааврууд бий бөгөөд Монголбанкнаас өөрийн хяналт шалгалт, мониторингийн үйл ажиллагаанд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудад нийцүүлэн тэдгээрийг байнга сайжруулан, шинэчилж ажиллаж байна. Хянан шалгагчдын зүгээс банкны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг тодорхойлох, тухайн байгууллагад чанарын үнэлгээг өгөх тал дээр мэргэжлийн түвшинд сайн ажилладаг. Санхүүгийн байгууллагыг үнэлэх төрөл бүрийн үнэлгээнд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг хослуулан ашиглаж байна. Хууль эрхийн хүрээнд нэгдсэн хяналт шалгалтыг хийх асуудал зохицуулагдаагүй байгаа тул Монголбанкны хянан шалгагчдын зүгээс тухайн банкны эзэмшигч компани, банкны группын талаарх мэдээллийг шаардах буюу эдгээр хуулийн этгээдүүд дотор санхүүгийн бус үйл ажиллагаа явуулдаг компаниуд байгаа тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх эрх зүйн чадамж байхгүй байна.
- **Бүртгэл, тайлан (ҮЗ 22).** Банкууд нь олон улсын бүртгэлийн стандартуудыг мөрдүүлж ажиллах үүрэг хүлээдэг бол Монголбанкны хянан шалгагчдын зүгээс шууд уулзалтууд зохион байгуулах замаар банкны хөндлөнгийн аудиторуудаас авсан мэдээлэлд суурилж үнэлгээг хийдэг байна.
- **Хууль тогтоомж зөрчсөнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо (ҮЗ 23).** Төв банкны тухай хуулиар банкны хяналт шалгалтын бодлого, нийгмийн сонирхол

буюу хадгаламж эзэмшигчдын эрх ашигт хохирол учруулж болох аливаа үйл ажиллагаа явуулах, явуулахыг завдсан тохиолдолд Монголбанкнаас банкуудад хяналт тавих замаар эдгээр үйлдлийг зогсоох, арилгуулах ажлыг авч хэрэгжүүлэх эрх зүйн чадамжийг бүрдүүлж өгсөн байна. Энэхүү арга хэмжээг бодит байдалд өргөнөөр ашигладаг бөгөөд үүнд дампуурсан банкуудыг татан буулгасан жишээг дурьдаж болно. Харин, торгуулийн дээд хэмжээний бодит үнэлгээ нь инфляцийн нөлөөгөөр буурснаас шийтгэлийн арга хэмжээ болох нөхцлийг хангах зорилгоор тэдгээрийг шинэчлэх шаардлагатай байна.

- **Нэгдсэн болон улс-дамнасан банкны хяналт шалгалт (ҮЗ 24–25).** Монголбанкны зүгээс нэгдсэн хяналт шалгалтыг авч хэрэгжүүлэх эрх зүйн чадамж бүрэлдээгүй ч албан бус замаар ерөнхий дүр зураг гаргах оролдлого хийдэг байна. Банкуудын нэгдсэн тэнцлийн дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцдог боловч зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо хянан шалгагчдад ирүүлсэн банкны охин компаниудын талаарх мэдээллийг ашиглан нэгдсэн тайланг гаргадаггүй байна. Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд банкны групп болон банкны үйл ажиллагаа дотор нь харьяалагддаг, илүү өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг группуудын талаарх бүрэн мэдээллийг авах эрхийг Монголбанкинд олгож буй бөгөөд ингэснээр Монголбанкны зүгээс тэрхүү бүлэгүүдэд хамаарах банкныг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн чадамж нь бүрдэх юм. Мөн түүнчлэн, Монголбанк болон СЗХ-ны хоорондын “Мэдээлэл солилцох журам”-аар санхүүгийн группуудад хийгдэх хяналт шалгалтыг ахлах хянан шалгагчдын асуудлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг одоо хэлэлцэж байна. Өнөөдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулагч/хөрөнгө оруулалтын компаниудын 100 хүртэлх хувь эзэмшлийн 6 арилжааны банкыг эс тооцвол Монгол улсад гадаадын аль нэг банкны салбар үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа бөгөөд Монголын банкуудын хувьд ч тэд гадаадад өөрийн төлөөлөгчийн газрыг байгуулснаас хэтрээгүй байна.

62. 2007 оны 5 дугаар сард хийгдсэн БҮЗ-ын үнэлгээний дараагаар Монгол банкнаас банкны хяналт шалгалт, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр олон ажил хийгдсэн байна. БҮЗ-ын үнэлгээ хийгдсэний дараах ажил болохын хувьд тэдгээрийг энэхүү үнэлгээнд оруулж тооцоогүй боловч ирээдүйд хийгдэх үнэлгээнд БҮЗ-д нийцүүлсэн байдал сайжирсан нь харагдах боломжтой юм.

Хүснэгт 5. Базелийн үндсэн зарчмуудын хэрэгжилтийн үнэлгээний хураангуй

Үндсэн зарчим	Тайлбар
1. Зорилго, хараат бус байдал, эрх мэдэл, ил тод байдал болон хамтын ажиллагаа	МБ-ны хараат бус байдал болон мэдээлэл солилцооны хүрээнд зарим нэг дутагдал байна.

Үндсэн зарчим	Тайлбар
1.1 Хариуцлага болон зорилго	Хариуцлага болон зорилго нь тодорхой.
1.2 Хараат бус, ил тод, тунгалаг байдал	Монголбанкны хараат бус байдал нь шаардлага хангахаар боловч МБ-ны ерөнхийлөгчийг ажил үүргээс чөлөөлөх тухай нөхцөлүүд ихээхэн бүрхэг.
1.3 Хууль, эрх зүйн орчин	Зохих хууль, эрх зүйн орчин бүрэлдсэн.
1.4 Эрх зүйн чадамж	Зохих эрх зүйн чадамж бүрэлдсэн.
1.5 Хуулийн хамгаалалт	Хуулинд хянан шалгагчдыг хамгаалалтад авах тухай аливаа заалт байхгүй.
1.6 Хамтын ажиллагаа	Хамтын ажиллагааны талаарх зохицуулалтууд байгаа боловч мэдээлэл солилцооны нууцлалын асуудлыг чангатгаснаар улам сайжруулах бололцоо бий.
2. Хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагаа	Хуулиар банкинд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг нарийн тодорхойлж өгсөн.
3. Зөвшөөрөл олгох шалгуур	Банкны удирдлага болон ТУЗ-ийн гишүүдэд тавигдах ажлын туршлагын шаардлагыг чангатгах, банкны лицензийг хураах Монголбанкны эрх мэдлийг нэмэгдүүлэх шаардлагатай.
4. Томоохон хувь эзэмшлийг шилжүүлэх	Томоохон хувь эзэмшлийг тодорхойлох болон сонирхлыг хянах асуудлыг илүү албан ёсны болгон хуульчлах шаардлагатай.
5. Томоохон хөрөнгө оруулалт	Томоохон хөрөнгө оруулалтын талаар мэдэгдэх, холбогдох зөвшөөрлийг авах эсэх болон банкны-бус үйл ажиллагаанаас үүсч болох эрсдлийн мониторингид хуулийн цоорхой бий болсон.
6. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	Хэдийгээр Монголбанкнаас албан бус байдлаар нэгдсэн тайлан дахь өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцож гаргадаг боловч албан тайланд зөвхөн банкны өөрийн хөрөнгөд үнэлгээг хийж ирүүлдэг байна.
7. Эрсдлийг удирдах ажиллагаа	Хяналт шалгалтын тогтолцоо нь шаардлага хангахуйц боловч томоохон шинэчлэл хийхээр ажиллаж байна.
8. Зээлийн эрсдэл	Зээлийн эрсдэлд хийх хяналт шалгалт хангалттай.
9. Асуудалтай активууд, тэдгээрийн болзошгүй алдагдлын нөөцийн сан	Болзошгүй алдагдлын санг байгуулж, түүнд хяналт тавих ажиллагаа хангалттай түвшинд хийгддэг.
10. Нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцын хязгаарлалт	Хоорондоо холбоотой этгээдийг тодорхойлсон хуулийн тодорхой заалт үгүй бөгөөд нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцыг тодорхойлох тооцооллын аргатай байх нь чухал.
11. Холбогдох этгээдийн багц	Хэм хэмжээ нь ерөнхийдөө хангалттай боловч Банкны тухай хуулийн ТУЗ-ийн гишүүдэд олгох зээлийн талаарх заалтыг сайжруулах шаардлагатай.

Үндсэн зарчим	Тайлбар
12. Улсын болон шилжүүлгийн эрсдэл	Хяналтын ажиллагаа хангалттай түвшинд боловч банкуудын тайланд тавих шаардлагыг чангатгах хэрэгтэй.
13. Зах зээлийн эрсдэл	Зохих хяналт шалгалтын бодлого, журам заавар байгаа боловч ихэвчлэн томоохон, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг банкуудад чиглэсэн бөгөөд гадаад валют болон үнэт металлыг тусад нь заагласан хязгаарлалт байхгүй.
14. Хөрвөх чадварын эрсдэл	Өргөн цар хүрээг хамарсан хөрвөх чадварын эрсдлийн журмыг боловсруулах шаардлагатай.
15. Үйл ажиллагааны эрсдэл	Үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой журам заавар болон шаардлагуудыг тогтоож өгсөн. Жижиг банкуудын хувьд эрсдлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай.
16. Банкны тэнцэл дэхь хүүгийн эрсдэл	Эрсдлийн удирдлагын системийг зохих түвшинд шалгадаг боловч зарим жижиг банкуудын хувьд хяналт шалгалтын шаардлагуудыг ханган ажиллах тал дээр анхаарууштай.
17. Дотоод хяналт ба аудит	Монголбанкнаас банкуудын дотоод аудитын үйл ажиллагааг эрсдэлд илүү чиглүүлэхийг шаарддаг.
18. Санхүүгийн үйлчилгээг зүй бусаар ашиглах	Монголбанкны СМА нь шинээр байгуулагдсан, хүн хүчний хомсдолтой байгаа бөгөөд мэргэжлийн сургалтуудыг явуулах шаардлагатай байна.
19. Хяналт шалгалтын арга барил	Хянан шалгагчид нь банкуудын талаарх бүрэн ойлголттой .
20. Хяналт шалгалтын техник	Зохих журам, заавар бий бөгөөд хяналт шалгалт нь сайн хийгддэг.
21. Хяналт шалгалтын тайлан	Банкнаас улирал бүр тайлан мэдээг ирүүлэхийг шаарддаг боловч энэ нь дан ганц банкны өөрийн тайлангаар хязгаарлагддаг.
22. Бүртгэл, тайлан	Ерөнхийдөө шаардлагын түвшинд боловч банкны хөндлөнгийн аудиторуудын оролцоог нэмэгдүүлэх боломжтой.
23. Хянан шалгагчдын шийтгэвэр ноогдуулах болон арга хэмжээ авах эрх зүйн чадамж	Зохих эрх зүйн чадамж бүрдсэн бөгөөд амьдралд хэрэглэгддэг боловч торгуулийн хэм хэмжээ нь инфляцийн нөлөөгөөр хэтэрхий бага байна.
24. Нэгдсэн хяналт шалгалт	Нэгдсэн хяналт шалгалт хийгддэггүй боловч Төв банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд холбогдох өөрчлөлтүүд тусгагдаж байна.
25. Улс дамнасан хяналт шалгалтын харилцаа	Монгол улс дахь гадаадын банкуудын үйл ажиллагаа хязгаарлагдмал бөгөөд Монголын банкуудын хилийн чанад дахь үйл ажиллагаа зөвхөн төлөөлөгчийн газраас хэтрэхгүй байна.

Зөвлөмж болгосон ажлын төлөвлөгөө болон эрх баричгдын зүгээс өгсөн хариултууд.

Зөвлөмж болгосон ажлын төлөвлөгөө

Хүснэгт 6. Базелийн Үндсэн Зарчмуудын Хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр зөвлөмж болгосон ажлын төлөвлөгөө

Харгалзах зарчим	Зөвлөмж болгож буй арга хэмжээнүүд
ҮЗ 1.2 Хараат бус, тайлагнах, тунгалаг байдал	Монголбанкны ерөнхийлөгчийг албан үүргээс чөлөөлөх тухай нөхцлийг илүү нарийн тусгах.
ҮЗ 1.5 Хуулийн хамгаалалт	Монголбанк болон түүний ажиллагсадыг хамгаалалтад авах тухай заалтыг Төв банкны тухай хуулинд нэмж оруулах
ҮЗ 3. Банкны үйл ажиллагааны зөвшөөрөл олгох шалгуур	Шинээр үүсгэн байгуулагдах банкинд тавих хяналт шалгалтыг гүнзгийрүүлэх; банкны удирдлага болон ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлагуудыг нарийвчлан заах; лиценз авах үедээ худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон бол лицензийг хураах тухай заалтыг нэг жилээр хязгаарласан заалтыг хасах гэсэн өөрчлөлтүүдийг холбогдох журам, зааварт оруулж, шаардлагатай хууль, эрх зүйн актыг батлах
ҮЗ 4. Томоохон хувь эзэмшлийг шилжүүлэх	Банкны тухай хуульд томоохон хувь эзэмшлийн болон сонирхлыг хянахтай холбоотой тодорхойлолтыг олон улсын стандартад нийцүүлсэн байдлаар оруулах.
ҮЗ 5. Томоохон хөрөнгө оруулалт	Банкны тухай хуульд буюу холбогдох журам, зааварт эзэмшигч компанийн талаарх ойлголтыг тусгаж банкны зонхилох хувь буюу хөрөнгө оруулалтыг эзэмших тохиолдолд зохих мэдэгдлийг хүргүүлэх буюу зөвшөөрөл авч байх тухай зааж өгөх.
ҮЗ 6. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	Нэгдсэн тайланд үндэслэж тайлан мэдээ, тооцоог гаргадаг болох
ҮЗ 7. Эрсдлийн удирдлагын ажиллагаа	Шинэ Зохистой удирдлагын журмыг мөрдүүлж буй байдал болон эрсдлийн удирдлагын бодлогыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд газар дээрх хяналт шалгалтаар дамжуулан бүрэн үнэлгээг бүх банкуудыг хамруулсан байдлаар яаралтай дүгнэж гаргах.
ҮЗ 10. Нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцын хязгаарлалт	Нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцыг хянах үүднээс Банкны тухай хуулийн “холбогдох этгээд”-ийн талаарх тодорхойлолтыг ойлгомжтой бөгөөд тодорхой болгох шаардлагатай. Мөн түүнчлэн нэг зээлдэгчийн эрсдэлтэй активын багцыг тодорхойлж, түүнийг тооцоолох аргачлалыг нэвтрүүлэх.

Харгалзах зарчим	Зөвлөмж болгож буй арга хэмжээнүүд
ҮЗ 11. Холбогдох этгээдийн багц	Банкны тухай хуульд болон бусад холбогдох журам, зааварт захирал болон ТУЗ-ийн гишүүн, тэдгээрийн холбогдох этгээдтэй хамааралтай аливаа зээл буюу бусад гүйлгээг тэднийг оролцуулахгүйгээр шийдвэрлэх тухай заах.
ҮЗ 13. Зах зээлийн эрсдэл	Гадаад валют болон үнэт металлын хувьд тус тусад нь ялгавартай позицийн хязгаарлалтыг зааж өгөх.
ҮЗ 14. Хөрвөх чадварын эрсдэл	Өргөн хүрээг хамарсан хөрвөх чадварын журмыг гаргах.
ҮЗ 15. Үйл ажиллагааны эрсдэл	Жижиг банкны байгууллагуудын хувьд өөрсдийн үйл ажиллаганы цар хүрээнд тохирсон үйл ажиллагааны эрсдлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэхийг шаардах.
ҮЗ 16. Банкны тэнцэл дэх хүүгийн эрсдэл	Бүх банкуудаас өөрсдийн үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон хүүгийн эрсдлийг тооцох аргачлалыг хэрэгжүүлэхийг шаардах.
ҮЗ 17. Дотоод хяналт ба аудит	2006 онд батлагдсан Банкны Зохистой удирдлагын зарчмуудын (БЗУЗ) хэрэгжилтийг 2008 оны эхний улиралд магадлах.
ҮЗ 18. Санхүүгийн үйлчилгээг зүй бусаар ашиглах	СМА-ны хүний нөөцийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр хянан шалгагчдыг илүүтэй сургах.
ҮЗ 21. Хяналт шалгалтын тайлан	Нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тухай журам гаргах.
ҮЗ 22. Бүртгэл, тайлан	Гадны аудиторуудтай харьцах харьцааг тогтмолжуулах.
ҮЗ 23. Хянан шалгагчдын шийтгэвэр ноогдуулах болон арга хэмжээ авах эрх зүйн чадамж	Торгуулийн хэм хэмжээг шинэчлэх, нэмэгдүүлэх.
ҮЗ 24. Нэгдсэн хяналт шалгалт	Нэгдсэн хяналт шалгалтын тухай нэмэлт өөрчлөлтийг Банкны тухай хуульд оруулах.
ҮЗ 25. Улс дамнасан хяналт шалгалтын харилцаа	Монголын банкуудын олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, эсрэгээр гадаадын банкуудын Монгол улсад үйл ажиллагаа явуулах боломжийг хангах үүднээс Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах, холбогдох журам, зааварыг боловсруулан гаргах.

Эрх бүхий байгууллагын зүгээс үнэлгээнд өгсөн хариу

63. Монгол улсын эрх бүхий байгууллагаас ҮАБХШБҮЗ-ын үнэлгээтэй санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн юм. Тэдний зүгээс 2007 оны 5 сард хийгдсэн ҮАБХШБҮЗ-ын үнэлгээнээс хойш хяналт шалгалтын болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр дорвитой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсний үр дүнд ҮАБХШБҮЗ-ын хэрэгжилт сайжирна гэж үзэж буйгаа тэмдэглэсэн. Авсан арга хэмжээнүүдээс дурьдвал:

- МУҮАЭ/ТСТ-тэй холбоотойгоор сэжигтэй гүйлгээний тайлан, харилцагчийг таньж мэдэх асуудлууд шийдвэрлэгдсэн бөгөөд банкуудаас бүх том дүнтэй багцын (өмнө нь зөвхөн 20 том зээлдэгчийн тайланг ирүүлэхийг шаарддаг

байсан байна) тайланг ирүүлэх шинэ журам гарснаар дээрх эрх зүйн харилцаануудыг чангатгажээ;

- Аливаа хувьцаа эзэмшигч компани болон банкны эзэмшлийн бүтцэд нөлөөлөх холбогдох этгээдүүд өөрчлөгдөх, банкны удирдлага буюу бүтцэд нь өөрчлөлт орох тохиолдолд Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлага тавих болсон нь нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог хүчирхэгжүүлэх, нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор банкнаас мэдээлэл гаргуулж авах Монголбанкны эрх зүйн чадамжийг нэмэгдүүлжээ;
- Хамгийн их эрсдлийн (VAR) аргыг эрсдлийн үнэлгээнд ашиглаж буй банкуудаас илүү нарийн шинжилгээний аргачлал ашиглахыг шаардаж байгаа бөгөөд мэдрэмтгий байдлын болон орчны шинжилгээг хийх, буцаан шалгах замаар өөрсдийн дотоодын загварчлалыг шинэчилж байх шаардлагуудыг тавьдаг болжээ.

**Мөнгөний болон Санхүүгийн бодлогын ил тод байдлыг хангах
оновчтой арга хэмжээний хэм хэмжээ:**

Мөнгөний бодлого

Ерөнхий

64. Энэхүү үнэлгээг мөнгөний бодлоготой холбогдуулан ОУВС-аас гаргасан *Мөнгөний болон Санхүүгийн бодлогын ил тод байдлыг хангах ёс зүйн хэм хэмжээ* (цаашид МСБ-ын ил тод байдлын ёс зүй гэх)-г Монголбанкнаас хэрхэн ханган ажиллаж буй байдалд хийсэн болно. Үнэлгээ нь МСБ-ын ил тод байдлын ёс зүйн бичиг баримтад суурилсан бөгөөд түүнийг ханган ажиллаж буй магадлахдаа МСБ-ын ил тод байдлын ёс зүйн Дагалдах бичиг баримтуудыг үндэслэв.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт—Тойм

65. Мөнгөний бодлогын үнэлгээнд холбогдох байгууллага нь Монголбанк юм. Монголбанк нь 1991 оны 5 дугаар сард банкны тухай шинэ хуулиар хоёр-шатлалт банкны тогтолцоо бүрдснээр хуучин Улсын банкны суурин дээр байгуулагджээ. Монгол улсад мөнгөний бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хүлээснээс гадна Монголбанк нь: мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр, тооцоог зохион байгуулах болон гадаад валютын улсын нөөцийг эзэмшин зохицуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

66. Хуульд зааснаар мөнгөний бодлогын үндсэн зорилго нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Өөрийн үндсэн зорилгын хүрээнд Монголбанк нь санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлдэг байна.

67. Мөнгөний бодлогын чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг Монголбанк болон парламент (“Улсын Их Хурал”) гэсэн хоёр байгууллага авч хэрэгжүүлж байна. Монгол улсын Үндсэн хуулиар (1992, 1 дүгээр сарын 13) “парламент нь ...дараах чиглэлээр өөрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж, шийдвэр гаргана: ... (7) Төрийн сангийн ... болон мөнгөний бодлогыг тодорхойлно.” гэж заажээ. Монголбанк нь статусын хувьд засгийн газраас хараат бус бөгөөд парламентийн зүгээс мөнгөний бодлогын үйл ажиллагаанд интервенци хийх нь хориотой байдаг. Монголбанк нь ирэх жилд авч хэрэгжүүлэх мөнгөний бодлогын саналаа “мөнгөний бодлогын үндсэн чиглэл” хэлбэрээр парламентаар хянуулж, батлуулахаар жил бүр өргөн барьдаг. Парламентэд мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг өргөн барихаас өмнө Монголбанк нь өөрийн вэб хуудсанд байрлуулж нийтээр хэлэлцүүлдэг байна. Эцэслэгдэн батлагдсаны дараа үндсэн чиглэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлдэг.

68. Монголбанкны ерөнхийлөгч нь шийдвэр гаргах эрх мэдлийг дангаар хэрэгжүүлдэг. Ерөнхийлөгчид зааварчилгаа, зөвлөгөө өгөх үүрэг бүхий

ерөнхийлөгчөөр толгойлуулсан дээд удирдлага болон хоёр гадны гишүүдээс бүрдсэн 14 суудалтай Захирлуудын Зөвлөл ажилладаг байна. Түүнээс гадна, Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавьж парламентэд өөрийн дүгнэлтээ тайлагнах үүрэг бүхий Хяналтын Зөвлөл ажиллана. Парламентаас Монголбанкны ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг зургаан жилийн хугацаатайгаар томилдог ажээ.

Үндсэн дүгнэлтүүд

69. Бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэхийн ач холбогдолыг үнэлж Монголбанкнаас сүүлийн жилүүдэд дорвитой арга хэмжээнүүдийг авч явуулсан бөгөөд ерөнхийдөө мөнгөний бодлогын ил тод байдал нь харьцангуй өндөр түвшинд байна. Гэвч мөнгөний бодлогын шийдвэр гаргалтын ил тод байдлыг цаашид сайжруулах нь зүйтэй. Мөн түүнчлэн Монголбанкны зохистой удирдлага, ялангуяа Ерөнхийлөгчийн ажлаа тайлагналтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

70. Мөнгөний бодлогын зорилтыг хуулиар тодорхойлохын хажуугаар нэлээд өргөн агуулгаар ойлгож, төрөл бүрээр тайлбарлах боломж нээлттэй байна. Өөрөөр хэлбэл, зорилтыг нарийвчлан тайлбарласан аливаа журам, заавар байхгүй байна. Үүний хажуугаар Монголбанкны зүгээс ч тэр өөрийн вэб хуудсанд болон бусад олон нийтэд хүргэх мэдэгдэлдээ өөрийн зорилтыг “үнийг тогтворжуулах” гэсэн энгийн байдлаар тайлбарладаг ажээ. Парламентаас улсын мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг хэрхэн шийдвэрлэж буй байдлыг нийтэд мэдээлдэг байна. Эдгээр ажиллагаа нь бодлогын зорилтыг тодруулах нэг талын арга зам болдог.

71. Мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар авч явуулах арга хэмжээний зөвлөмжүүдэд: (i) Монголбанкны мөнгөний бодлогын чиг үүрэг, хариуцлага болон зорилтын талаарх хуулийн тайлбаруудыг нэмэгдүүлэх; (ii) мөнгөний бодлогын шийдвэр, зорилтууд, арга хэрэгсэл болон тогтолцоог олон нийтэд мэдээлж, таниулах талаар ахиц гаргах; (iii) Монголбанкны ерөнхийлөгчийн ажлаа тайлагналтаас гадна Монголбанкны дотоод зохистой удирдлагын ажиллагааг сайжруулах; (iv) өөрийн ажил үүргээ хэрэгжүүлэхэд нь таатай нөхцлийг хангах зорилгоор Монголбанкны ажиллагсад, албан хаагчдад хуулийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж өгөх зэрэг болно. Зөвлөмжүүдийн хураангуйг нэгтгэн Хүснэгт 8-д харуулав.

72. Төв банкны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Нэмэлт өөрчлөлтийн төсөл нь батлагдаж, мөрдөгдөж эхэлсэн тохиолдолд мөнгөний бодлогын ил тод байдалд оршиж буй хэд хэдэн доголдолтой зүйлийг засварлах нөхцөл бүрдэнэ. Одоогийн байдлаар Монголбанк нь дотоод зохистой удирдлага болон мөнгөний бодлогын ил тод байдлыг хөндсөн хэд хэдэн заавар, журмуудыг боловсруулах шатанд ажиллаж байна.

Хүснэгт 7. Мөнгөний бодлогын ил тод байдлын хэм хэмжээнд хийсэн ажиглалтын хураангуй:

Зарчим	Дүгнэлт
1.1 Мөнгөний бодлогын тогтолцоо, түүний эцсийн зорилгыг холбогдох хууль, журамд тодорхой заах	ТБ-ны тухай хуульд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага, түүний бодлогын чиг үүргүүдийг тодорхойлон заасан байна. Монголбанкны үндсэн зорилгыг үнийн тогтвортой байдлыг хангах, хоёрдогч зорилгуудыг валютын ханшийн тогтвортой байдал болон санхүүгийн системийн тогтвортой байдалыг хангах гэж засварлах нь зүйтэй.
1.2 Мөнгөний болон сангийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын харилцааг тодорхой заах	Монголбанк болон засгийн газрын хоорондын ажил үүргийн харилцааг ТБ-ны тухай хуульд тодорхой зааж өгсөн байгаа боловч төв банкнаас засгийн газарт зээл олгох болон ТБ-ны эдийн засгийн бусад салбар дахь оролцоо, ТБ-ны цэвэр орлогын тодорхойлолт зэрэгт зарим нэг дутагдалтай зүйлс байна.
1.3 Монголбанкны Засгийн газрын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх ажил үүргийг тодорхой заах	ТБ-ны тухай хуульд засгийн газрын нэрийн өмнөөс ТБ-ны авч хэрэгжүүлэх чиг үүргийг заасан байна.
2.1 Мөнгөний бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах тогтолцоо, хэрэгсэл болон аливаа зорилтуудыг нийтэд мэдээлж, тайлбарлаж байх	Өргөн хүрээнд авч үзвэл, мөнгөний бодлогын зорилтууд, хэрэгсэлүүд, тогтолцоо нь Монголбанкны вэб хуудас болон төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлэгдэж тайлбарлагддаг. Мөнгөний бодлогын хэрэгсэлүүдийг хэрэгжүүлж буй байдлыг Монголбанкны жилийн болон улирлын тайланд тайлбарлаж нийтэд мэдээлдэг байна. Тухайн жилийн инфляцийн зорилтыг мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тодорхойлж Монголбанкны вэб хуудсаар дамжуулан нийтэд мэдээлдэг байна. Мөн түүнчлэн, 2007 онд Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг парламентад өргөн барихаас өмнө анх удаа нийтээр хэлэлцүүлэх зорилгоор өөрийн вэб хуудсанд байрлуулжээ.
2.2 Мөнгөний бодлогыг тодорхойлогч байгууллага нь эдийн засгийн хөгжлийн үндсийг тодорхойлж, мөнгөний бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц, ирээдүйн бодлогын төлөвлөгөө болон өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг олон нийтэд таниулж, мэдээлэх	Мөнгөний бодлогын талаарх шийдвэр гаргах эрх бүхий Мөнгөний бодлогын хороог үүсгэн байгуулах нь ач холбогдолтой байж болох юм. Тэр хүртэл, ерөнхийлөгчийн аливаа гаргасан шийдвэрээ тайлагнах хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх үүднээс парламентад тайлагнах үүрэг бүхий Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх нь зүйтэй.

Зарчим	Дүгнэлт
2.3 Мөнгөний бодлогын хэрэгслүүдэд (байнгын байдаг хэрэгсэл “fine-tuning”-гээс бусад) гарсан өөрчлөлт тухай бүрийг тодорхой хугацаанд нийтэд мэдээлж, тайлбарлаж байх шаардлагатай.	Төв банкны тухай хуулиар Монголбанк нь мөнгөний бодлогын талаар авч хэрэгжүүлж буй хэрэгслүүд болон тэдгээрт гарч буй өөрчлөлтийг нийтэд мэдээлж байх үүрэгтэй гэж заажээ. Монголбанкнаас мөнгөний бодлого, түүний хэрэгслүүдэд өөрчлөлт оруулах тухай бүр тэрхүү шийдвэрийг гаргах болсон шалтгааныг зах зээлд оролцогчдод мэдээллдэг байна. Хэдийгээр практикт тийнхүү мэдээллийг тэр даруй мэдээлдэг боловч ямар хугацааны дотор амжиж мэдээлсэн байхыг тусгайлан заасан зүйл үгүй байна.
2.4 Төв банк нь мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад баримталж буй үндсэн чиглэлүүдийн талаар урьдчилан заасан хугацааны дотор нийтэд мэдээллэх	Монголбанк нь мөнгөний бодлогод гарч буй ахиц, хөгжил болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн тухай тайлбарыг улирал тутам гаргадаг өөрийн тайланд тусган харуулдаг байна.
2.5 Мөнгөний бодлогын хууль, эрх зүйн зохицуулалтын түвшинд аливаа өргөн цар хүрээтэй техник өөрчлөлт хийгдэх тохиолдолд тодорхой хугацааны туршид олон нийтээр хэлэлцүүлж, санал авах	Мөнгөний бодлогын хууль, эрх зүйн зохицуулалтын түвшинд өргөн цар хүрээтэй өөрчлөлт гарах тохиолдолд салбарын холбогдох этгээдүүдээс урьдчилан санал авч, хэлэлцүүлдэг байна.
2.6 Санхүүгийн байгууллагуудаас төв банкинд мөнгөний бодлогын зорилгоор ирүүлж буй аливаа тайлан мэдээний талаарх журам, заавар нь олон нийтэд нээлттэй байх	Хэдийгээр ТБ-ны тухай хуулиар Монголбанк нь банк, хувь хүн болон хуулийн этгээдүүдээс мэдээлэл авах эрх нь нээлттэй боловч мөнгөний бодлогын зорилгоор санхүүгийн байгууллагуудаас Монголбанк нь аливаа, тайлан мэдээ авах асуудлыг зохицуулсан тусгай журам байхгүй байна.
3.1 Төв банкнаас гаргаж буй аливаа илтгэл, мэдээлэл нь ОУВС-ын мэдээллийг түгээх стандартын дагуу цар хүрээ, хамрах хугацаа, мэдээллийн шинэ соргог байдал болон олон нийтэд хүрч буй байдал зэрэг хэм хэмжээг хангах	Монгол улс нь 2000 оны 8 дугаар сараас эхлэн Ерөнхий Мэдээлэл Түгээлтийн Системд нэгдэж, гишүүнээр элссэн байна. Мэдээлэл нь тухайн тайлангийн хугацааны эцэст тэр даруй нийтийн хүртээл болдог .
3.2 Төв банк нь өөрийн тайлан тэнцлийг урьдчилан товлосон хугацаанд, тодорхой хугацааны давтамжтайгаар олон нийтэд мэдээлж, хэсэг хугацаа өнгөрөхийн хирээр зах зээл дэх өөрийн нийт гүйлгээний талаар хэсэгчлэн нийтэд мэдээлж байх	Монголбанк нь вэб хуудсаараа дамжуулан сар болгоны тайлан мэдээгээр өөрийн тайлан тэнцлээ нийтэд мэдээллдэг . Түүнээс гадна, жил тутмын аудитлагдсан санхүүгийн тайлангаа өөрийн Жилийн Тайланд хавсаргаж нийтийн хүртээл болгодог байна. Хэдийгээр Монголбанк нь мэдээлэл түгээх өөрийн дотоодын журамтай боловч олон нийтэд мэдээлэлийг тодорхой хуваарийн дагуу хүргэж байх асуудлыг зохицуулсан журам гаргахаар ажиллаж байна. Мөн түүнчлэн, жилийн тайланг хэвлэн гаргах эцсийн хугацааг заасан зохицуулалт байхгүй. Нөгөө талаар, зах зээл дээрх нийт гүйлгээний талаарх мэдээллийг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр салгаж мэдээлдэггүй байна.

Зарчим	Дүгнэлт
3.3 Төв банк нь олон нийтэд түгээх мэдээллийн үйлчилгээг бий болгож, ажиллуулах	Монголбанк нь олон нийттэй харьцах мэдээллийн албатай бөгөөд мэдээллийн вэб хуудсыг англи хувилбарын хамт ажиллуулдаг.
3.4 Төв банкнаас гаргасан аливаа журам, заавар нь олон нийтэд нээлттэй байх	Журам, заавар нь бүрэн эхээрээ олон нийтэд нээлттэй байдаг.
4.1 Төв банкны ажиллагсад нь мөнгөний бодлогын болон өөрийн байгууллагын барьж буй бодлогын зорилтууд, тэдгээрт хүрч ажиллах ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тодорхой эрх бүхий байгууллагын өмнө таниулж, тайлбарлах чадвартай төдийгүй улсын эдийн засаг, санхүүгийн системийн талаар үзэл бодлоо солилцдог байх	Жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Монголбанкнаас дараа жилд баримтлах төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн саналын төслийг парламентэд өргөн барьда. Энэ үеэр Монголбанкны ерөнхийлөгч, бодлого боловсруулах газрын захирлуудын хамт Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй ажил, мөнгөний болон санхүүгийн салбарын хөгжил, бодлогын зорилтууд, тэдгээрт хүрэх арга хэмжээний саналуудын талаар парламентэд тайлагнадаг байна. Түүнээс гадна, Монголбанкны удирдлага нь парламентийн байнгын хороод, хамтарсан хуралдаан болон засгийн газрын кабинетийн хуралдаанд мөнгөний бодлогын болон улсын эдийн засаг, санхүүгийн системийн талаарх үзэл бодлоо илэрхийлж, саналаа хэлдэг.
4.2 Төв банк нь өөрийн үйл ажиллагааны аудитлагдсан санхүүгийн тайланг урьдчилан зарласан хуваарийн дагуу олон нийтийн хүртээл болгох	Монголбанкны жилийн тайланд Монголбанкны аудитлагдсан тайлан тэнцэл болон орлогын тайлан хавсаргагддаг байна. Монголбанкны Хяналтын зөвлөлөөс гадаад валютын нөөц, хөрөнгө оруулалтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх харилцааг хамарсан Монголбанк дахь зохистой удирдлагыг хангах тал дээр илүү хариуцлагатай үүрэг хүлээх шаардлагатай.
4.3 Төв банкны тухайн жилийн үйл ажиллагааны орлого, зарлагын талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд тайлагнах	Орлого, зарлагатай холбоотой мэдээлэл нь Монголбанкны жилийн тайлан дахь санхүүгийн тайлангийн хэсэгт тусгагддаг .
4.4 Төв банкны ажилтан, албан хаагчдын хувийн орлого олох үйл ажиллагааны хэм хэмжээ болон сонирхлын зөрчил үүсгэх аливаа өр төлбөрийн эсрэг дүрэм, журмыг олон нийтэд таниулах	Монголбанкны ажилтан нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа аливаа зохисгүй үйл ажиллагаа явуулахаас албан ёсоор урьдчилан сэргийлсэн хуулийн заалт Төв банкны тухай болон Банкны тухай хуулийн аль алинд нь байхгүй байна.

Зөвлөмж болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө болон эрх баригчдын зүгээс өгсөн хариу

Хүснэгт 8. Мөнгөний бодлогын ил тод байдлыг сайжруулах талаар авч явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний зөвлөмж

Зарчим	Зөвлөмж болгосон ажил
1.1, 1.1.1 Мөнгөний бодлогын ялгавартай зорилтуудыг хуулиар тодорхойлох, нийтэд мэдээлж таниулах	ТБ-ны үндсэн зорилтыг үнийг тогтвортой байлгах, хоёрдогч зорилтуудыг гадаад валютын ханшийн тогтвортой байдал болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах гэж шинээр тодорхойлох нь зүйтэй.
1.1.6 Төв банкны бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд засгийн газрын зүгээс нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, тэрхүү үйл ажиллагааг олон нийтэд хэрхэн мэдээллэх асуудлыг зохицуулсан хуулийн заалттай байх	Төрөөс тухайн жилд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлах явцад парламентийн зүгээс Монголбанкны хуулийн хариуцлагыг хөндсөн аливаа сонирхлын зөрчил гаргахгүй байх, санхүүгийн секторын хөгжлийн тулгамдсан асуудлын талаарх үндсэн чиглэлийг илүү нарийвчлан тусгах
1.2.3 Анхдагч зах зээл дээр засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагаан дахь төв банкны шууд оролцоог олон нийтэд мэдээлж байх.	Анхдагч зах зээл дээрх засгийн газрын өрийн хэрэгслийг Монголбанкнаас худалдан авах асуудлыг нарийвчлан тусгасан төв банкнаас засгийн газарт зээл олгох тухай шинэ журам гаргах
1.2.4 Төв банкны эдийн засгийн бусад салбар дахь оролцоог олон нийтэд энгийн ойлгомжтой, нээлттэй байлгах	Эдийн засгийн бусад салбар дахь төв банкны оролцоог олон нийтэд мэдээллэх талаар дотоодын журмыг Монголбанкнаас гаргах эсхүл Төв банкны тухай хуулинд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах нь зүйтэй
1.2.5 Төв банкны ашгийн хуваарилалт болон өөрийн хөрөнгийн талаарх мэдээллийг нийтэд хүргэдэг байх	Амьдралд төв банкны цэвэр ашгийг тооцоходоо Төв банкны тухай хуулинд заасан тодорхойлолтын дагуу буюу гадаад валютын нөөцийн удирдлагаас олсон хөрөнгө оруулалтын ашгийг оруулан тооцдог байна.
2.2 Мөнгөний бодлогыг тодорхойлогч байгууллага нь эдийн засгийн хөгжлийн үндсийг тодорхойлж, мөнгөний бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц, ирээдүйн бодлогын төлөвлөгөө болон өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг олон нийтэд таниулж, мэдээллэх	Мөнгөний бодлогын шийдвэр гаргах эрх бүхий Мөнгөний Бодлогын Зөвлөлийг байгуулах талаар авч хэлэлцэх нь ач холбогдолтой байж болох юм. Тэр хүртэл, ерөнхийлөгчийн аливаа шийдвэр гаргасан шийдвэрээ тайлагнадаг тогтолцоог өндөржүүлэх үүднээс парламентад тайлагнах үүрэг бүхий Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй.
2.3.1 Төв банк нь мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад баримталж буй үндсэн чиглэлүүдийн талаар урьдчилан мэдэгдсэн хуваарийн дагуу нийтэд мэдээллэх	Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад баримталж буй үндсэн чиглэлүүдийн талаар урьдчилан мэдэгдсэн хуваарийн дагуу нийтэд мэдээлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Зарчим	Зөвлөмж болгосон ажил
3.2.2 Төв банкнаас явуулсан мөнгөний зохицуулалтын гүйлгээнүүд „, дахин санхүүжилтийн хэмжээ болон нөхцөл, бусад төв банкны мөнгөний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг (арилжааны нууцлалын байдлаас хамааран) урьдчилан заасан хуваарийн дагуу олон нийтэд мэдээллэх	Аливаа үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн тухай бүр Монголбанкнаас тэрхүү үйл ажиллагааны ангилалаар задалж, тайлагнах
4.2.2 Дотоод аудитын тогтолцоо гэх мэт үйл ажиллагааны найдвартай байдлыг хангахад шаардагдах дотоодын зохистой удирдлагын зохицуулалтыг нийтэд мэдээллэх шаардлагатай.	Олон улсын туршлагын дагуу Монголбанкны Хяналтын Зөвлөлд Монголбанкны эрсдлийн удирдлагын журам болон гадаад валютын нөөцийн удирдлагыг хянах давуу эрх мэдлийг олгосон заалтыг Төв банкны тухай хуульд нэмж оруулах шаардлагатай. Хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл Монголбанкны зүгээс эдгээр журам, зааврын талаар мэдэгдэж байх нь чухал
4.4.1 Төв банкны ажилтан, албан хаагчдаас өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь таатай нөхцөл бүрдүүлэх үүднээс тэдгээрийн хуулийн хамгаалалтын талаарх мэдээллийг нийтэд мэдээллэдэг байх	Төв банкны ажилтан, албан хаагчдаас өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь таатай нөхцөл бүрдүүлэх үүднээс тэдгээрийн хуулийн хамгаалалтын талаарх заалтыг Төв банкны тухай хуульд нэмж оруулах

Эрх бүхий байгууллагын зүгээс үнэлгээнд өгсөн хариу

73. Монголбанк нь ССҮХ-ийн багийн үнэлгээгээр бодлогын ил тод байдал нь ерөнхийдөө өндөр түвшинд байгаа гэж үнэлэгдсэн явдалд баяртай байгаа бөгөөд цаашид мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх, үр ашигтай байдлыг хангах, дээшлүүлэх зорилгыг тавьж байна. Шинжээчдийн ажигласнаар Монголбанк нь сүүлийн жилүүдэд мөнгөний бодлогын агуулга, ажиллагаанд гарсан өөрчлөлтийг олон нийтэд ойлгон ухааруулах чиглэлээр мөнгөний бодлогын тогтолцоо, үйл ажиллагааг нийтэд хүргэх харилцаагаа өргөтгөн нэмэгдүүлсэн чухал алхамуудыг хийсэн Ялангуяа, парламентаар хэлэлцүүлж буй төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд дараа жилийн инфляцийн зорилтыг тусган харуулж байна. Монголбанкны жилийн тайланд эдийн засгийн хөгжлийн талаарх сүүлийн үеийн нарийвчилсан үнэлгээ болон мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаарх дүгнэлтийг оруулдаг болсон. Мөн түүнчлэн Монголбанк нь өөрийн мөнгөний зах зээлийн үйл ажиллагааны талаар нарийвчилсан мэдээллийг нийтэлж эхэлсэн.

74. Монголбанкны ерөнхийлөгчөөс шийдвэр гаргах эрх мэдлийг хэрэгжүүлж буй одоогийн систем нь оновчтой бишийг байж болохыг Монголбанк зөвшөөрч байгаа бөгөөд хуулинд заасан мөнгөний бодлогын зорилттой холбоотойгоор зарим үл ойлгогдох байдал байна. Монголбанк нь энэ талаарх асуудлыг хөндсөн нэмэлт өөрчлөлтийг Төв банкны тухай хуульд оруулах хүсэлтээ парламентэд тавихаар төлөвлөж байна.